


DEZA
DDC
DSC
SDC
COSUDE



АМГТХЭГ

**Ашигт малтмал
газрын тосны хэрэг
эрхлэх газар**

Монголын хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн
хүрээнд байгалийн нөөцийн тогтвортой менежментийг
хэрэгжүүлэх **“БИЧИЛ УУРХАЙГ ДЭМЖИХ”**

ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГ

(2005 оны 7 сарын 1-нээс 2006 оны 12 сарын 31)

Улаанбаатар
2005 оны 10 сар

Гарчиг

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
2. УДИРТГАЛ	4
3. МОНГОЛ ОРНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ: НИЙГЭМ, СОЁЛ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ, БОДЛОГЫН АСУУДАЛ	5
3.1. ГАЗАР ЗҮЙН БАЙРЛАЛ	5
3.2. ЭДИЙН ЗАСАГ	6
3.3. НИЙГМИЙН АСУУДАЛ	6
3.4. БАЙГАЛЬ ОРЧНЫ БАЙДАЛ	6
3.5. БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	7
3.6. БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ	7
4. МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ӨНӨӨГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ УЯЛДУУЛАН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХУВЬД ХОЛБОГДОХ БАЙДАЛ	7
4.1. Монгол улсын Бичил уурхай эрхлэгчид болон Өмнөд Америкийн Бичил уурхай эрхлэгчдийн хоорондын ялгаа	8
4.2. Монголын бичил уурхай эрхлэгчдийн талаарх мэдээлэл	10
4.2.1. Чухал холбогдох баримт бичгүүдийн жагсаалт	10
4.3. Бичил уурхай эрхлэгчдийн олборлолтоос үүдэх бусад хэлбэрийн үйл ажиллагаа	11
5. ШВЕЙЦАРИЙН ХӨГЖИЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГИЙН ДЭМЖЛЭГЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН АГУУЛГА	13
6.1. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ	13
6.1. ХАМТРАГЧ ТАЛУУДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ҮР ДҮН	13
6.2. Тулгамдаж буй асуудлуудад хийсэн дүн шинжилгээ	13
6.3. Үнэлгээний багийн ажлын явцад ба тус багийн дүгнэлт гарсны дараа үед хийгдсэн/авагдсан арга хэмжээнүүд	14
6.4. Латин Америкт ШХХАА-ийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн төслүүдийн туршлагыг ашиглаж болох талаар	14
6.5. Асуудлыг судлах ажлын ерөнхий бүтэц	16
6.6. Төслийн зорилго	17
6.7. Хүлээж буй үр дүн (ГАРАХ ҮР ДҮН, ТОГТВОРТОЙ БАЙДАЛ)	19
6.8. Хэрэгжүүлэлтийн үе шатууд:	19
6.8.1. Эхний үе шат 7/2005-12/2006: Бичил уурхайг дэмжих	19
6.8.2. Дараах үе шатанд гүйцэтгэгдэх бүрэн хэмжээний ажлуудыг багтаах төслийн бүтцүүд	23
6.9. Төслийн үйл ажиллагаа чиглэж буй хүмүүс ба төслөөс ашиг хүртэгчид	24
7.2. Төслийн зохион байгуулалт	25
7.3. Төслийн гол хамтрагч, харилцагч талууд ба тэдгээрийн боломж, чадавхийг үнэлэх ..	26
7.4. Төслийн хамтрагчид болон оролцогчид	31
7.5. Төслийг гүйцэтгэх дэвшүүлж буй схем	32
7.6. Нөөц бололцоо	33
7.6.1. ШХХАА-аас оруулах хувь нэмэр	33
7.6.2. Монгол улсын ба АМГТХЭГ-ын зүгээс оруулах хувь нэмэр	34
8. ЭРСДЭЛ, БОЛОМЖ, НӨХЦЛҮҮД	35

Товчилсон үгс

БУ	Бичил уурхай
BGR	Германы геологи, эрдэс баялагийн алба
BMBF	Герман улсын боловсрол шинжилгээний яам
CASM	Орон нутгийнхан болон бага оврын уулын үйлдвэрлэл (Дэлхийн Банкны хэрэглэдэг суурь ойлголт)
CIDA	Канадын олон улсын хөгжлийн агентлаг
GAMA	Перу улсад SDC-ийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн гар аргаар болон бага оврын олборлолтыг дэмжих төсөл
GDP	Үндэсний нийт бүтээгдэхүүн
GER	Дэлхий нийтийн байгаль орчны хөтөлбөр
GEUS	Данийн геологийн алба
GOM	Монгол улсын засгийн газар
GTZ	Deutsche Gesellschaft für Technische Zusammenarbeit GmbH
ILO	Олон улсын хөдөлмөрийн газар, Женев
IPEC	Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр
JICA	Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг
LA	Латин Америк
LSM	Том оврын уулын үйлдвэрлэл
MEDMIN	Болив улсад SDC-ийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн гар аргаар болон бага оврын олборлолтыг дэмжих төсөл
MMSD	Уул уурхай, эрдэс баялаг болон тогтвортой хөгжил
MoE	Байгаль орчны яам
MONEF	Монголын ажил олгогчдын холбоо
MRPAM	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
NGO	Төрийн бус байгууллага
PMSC	Эквадор улсад SDC-ийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн гар аргаар болон бага оврын олборлолтыг дэмжих төсөл
PMU	Төслийн зохион байгуулалтын (менежмент) нэгж
PSC	Төсөл зохицуулалтын хороо
SDC	Шведийн хөгжил хамтын ажиллагааны агентлаг
SNRM	Байгалийн баялгийг зөв зохистой удирдах
SSIA	Улсын мэргэжилийн хяналтын алба
USAID	Америкийн олон улсын хөгжлийн агентлаг
WB	Дэлхийн банк
YPO	Ажлын жилийн төлөвлөгөө

1. Товч танилцуулга

Монгол улсад байгалийн нөөцийн тогтвортой менежмент төсөл хэрэгжүүлэх боломжид үнэлгээ өгөх ажлыг 2005 оны 4, 5-р саруудад хийж, үйл ажиллагааны гол хэсгийг Бичил уурхайн салбарын үйл ажиллагаанд чиглүүлсэн юм.

Бичил уурхайн үйл ажиллагааг сүүлийн 5 жилийн хугацаанд нийгмийн эмзэг давхрага буюу хөдөөгийн ядуу иргэд албан бусаар эрхэлж байгаа бөгөөд тэдгээрийн ихэнх нь алт зарим хэсэг нь нүүрс, жонш зэргийг бага хэмжээгээр олборлож байна. Өнөөгийн байдлаар ийм албан бус олборлолт эрхэлж орлого олж, амьдралаа залгуулж буй хүний тоо 100,000 орчимд хүрээд байна. Эдгээр хүмүүсийн үйл ажиллагааг зохицуулах хууль дүрэм, бодлого зохицуулалт байхгүй учраас тэдний хувьд амьдралын баталгаа байхгүй, нийгмээс тусгаарлагдсан байдалтай амьдарч байна.

Бичил уурхайн үйл ажиллагааг хөдөөгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч болгох хөдөөгийн хүн амын тогтвортой амьжиргааг хангах үүднээс бичил уурхайн салбарын менежментийг бий болгон цаашид хөгжүүлэхэд Монгол улсад үзүүлж болох тусламж дэмжлэгт үнэлгээ өгөх зорилгоор энэхүү ажил хийгдсэн юм.

Өнөөдрийг хүртэл бичил уурхай эрхлэгчдийн талаар багагүй судалгаа хийгдсэн ч тэдний үйл ажиллагааг цэгцлэх, зохицуулалтанд оруулахад чиглэсэн тодорхой чиглэл зорилго бүхий төсөл хэрэгжээгүй байна. Иймээс, үнэлгээний ажлын хэсгээс гаргасан дүнг үндэслэн ийм төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй гэсэн шийдэлд хүрч төслийн эхний шатны үйл ажиллагааг 1.5 жилийн хугацаатай хэрэгжүүлж эхлэхээр болсон юм. Энэхүү төслийн үйл ажиллагааны эхний шатанд бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг хуульчлан баталгаажуулах хуулийн төслийг боловсруулах, тус салбарт оновчтой менежмент, бүтэц зохион байгуулалт, шинэ мэдлэг мэдээллийг бий болгох, хөгжүүлэх ажлууд хийгдэх юм. Шинэ мэдлэг, туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны агенлаг (ШХХАА)-аас Өмнөд Америкийн зарим орнуудад хэрэгжүүлж байгаа төслүүдийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах бөгөөд шинэ мэдлэг, техник технологийг Монгол улсад нэвтрүүлэх нь маш чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болно гэж үзэж байна.

Төслийг Монгол улсын Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар (АМГТХЭГ)-тай хамтран хэрэгжүүлэхээр тохироод байгаа бөгөөд төслийн хэрэгжилтийн явцад Уул уурхайн аврах алба, Аймаг, сумдын засаг захиргаа, уул уурхайн албан ба албан бус үйлдвэрүүд болон шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарч ажиллах болно. Цаашид Бичил уурхай салбарын бүтэц, зохион байгуулалтыг хөгжүүлэхэд тус улсын төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах болно.

2. Удиртгал

Монгол улсад байгалийн нөөцийн тогтвортой менежментийг бий болгох хөгжүүлэх төслийн хүрээнд Бичил уурхай эрхлэгчдэд тусламж дэмжлэг үзүүлэх боломж, нөхцөл байдлыг судлан үнэлгээ өгөх зорилгоор 2005 оны 4-р

сард ШХХАА -ийн Берн дахь төвд байгуулсан судалгааны ажлын хэсэг Монголд айлчилж энэхүү төслийн үндсэн утга санааг тодорхойлон гаргасан. ШХХАА нь урьд өмнө Өмнөд Америкийн зарим орон (Эквадор, Болив, Перу)-д бичил уурхайн үйл ажиллагааг байгаль орчны менежментийн асуудалтай уялдуулан хэрэгжүүлсэн төслүүдийн үйл ажиллагаа, тэдгээрийн туршага, ололт амжилтыг баталгаажуулах дэлгэрүүлэхийг зорьсон юм. Иймээс, судалгааны ажлын хэсэгт Латин Америкийн орнуудад төсөл хэрэгжүүлэхэд оролцсон Герман улсын зөвлөх “Проект консалт GmbH” компани болон ШХХАА-аас хэрэгжүүлсэн төслүүдийн үйл ажиллагаагаар байгуулагдсан МЭДМИН сан, Боливийн орон нутгийн зөвлөх байгууллагын мэргэжилтнүүд багтан орж ажилласан юм.

Судалгааны ажлын баг 2005 оны 4-р сарын 17 өдрөөс 5-р сарын 15-ны өдрийн хооронд хийж Монголд ирж ажил үүргээ гүйцэтгэсэн¹. Судалгааны ажил хийгдэж дууссантай холбогдуулан өмнөд-өмнөд (хөгжиж буй орнуудын)-ийн орнуудын хамтын ажиллагааны чуулга уулзалтыг 4-р сарын 29-нд Улаанбаатар хотноо “Чингис хаан” зочид буудалд зохион байгуулав.

Үүний дараагаар Берн, Улаанбаатар хотууд дахь ШХХАА хамтын саналаа дэвшүүлж төслийг хэрэгжүүлэх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Төслийн эхний шатны үйл ажиллагааны саналыг боловсруулсны дараа ШХХАА уг төслийг нийт 8 жилийн хугацаатай хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор нийт 8 сая швейцари франкийн санхүүжилтийг төлөвлөсөн. Төслийн үйл ажиллагааг эхний ба бэлтгэл шат (1 жил 6 сар), үндсэн шат (4 жил) ба төслийн төгсгөлийн үе шат гэсэн үе шаттайгаар хэрэгжүүлэх болно.

3. Монгол орны нөхцөл байдал: нийгэм, соёл, эдийн засаг, байгаль орчны нөхцөл байдал, бодлогын асуудал

3.1. Газар зүйн байрлал

Монгол улс нь газар зүйн байрлалын хувь төв Азид нийт 1,564 мянган хавтгай дөрвөлжин газар нутгийг хамран цөл ба цөлөрхөг хээр (нийт газар нутгийн нь 40 %), тал хээр (26 %), ойт хээр (8%), ой (4 %), уулархаг (22 %) байгалийн бүс бүслүүрт хуваагддаг. Тус улс нь 2,504, 000 хүн ам (2004-12 сар)-тай хүн амын нягтшил 1 х.д.км-т 1.6 хүн оногдож байгаа нь хүн ам бага сийрэг суурьшилтай орны тоонд ордог. Хүн амын 96.2 % нь бичиг үсэгтэй.

Монгол улс нь бэлчээр, ашигт малтмалын нөөц маш ихтэй байдаг нь тус орны эдийн засаг ер улс орны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдийн засгийн гол түлхүүр нь бэлчээрийн мал аж ахуй бөгөөд одоогоор энэ нь дотоодын нийт бүтээгдхүүн (ДНБ)-ний 30 %-ийг бүрдүүлдэг. 1990-ээд оноос эхлэн уул

¹ Феликс Каррилло (Болива) 2005 оны 5-р сарын 1 хүртэл Монголд байсан.

уурхайн салбар нь эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх салбарын нэг болон гарч ирсэн.

3.2. Эдийн засаг

Монголын уул уурхайн салбарын үйл ажиллагаа сүүлийн 5-10 жилд маш эрчимтэйгээр хөгжих болсон. 2004 оны байдлаар уг салбар нь ДНБ-ний 17% (1995 онд 6.1 %, 2001 онд 9.6% байсан), аж үйлдвэрийн нэмүү өртгийн 65%, нийт экспортын бүтээгдэхүүний 58%-ийг бүрдүүлж, гадаадын хөрөнгө оруулалтын 1/3-ийг эзэлж байна. Тус улсын эрдэс баялагийн олборлолтонд зэс, молибденээс гадна алт, нүүрс, жонш зэрэг нь чухал байр суурь эзэлдэг. Алт, нүүрс болон жоншийг хувь хүмүүс (“Бичил уурхай эрхлэгчид” гэж нэрлэдэг) албан бус байдлаар олборлож үндэсний үйлдвэрлэлд зохих хувь нэмэр оруулдаг гэж үздэг. Өнөөдөр жилийн алт олборлолтын хэмжээ 18тн (энэ нь албан ёсны тоо баримт боловч энд бичил уурхай эрхлэгчдийн олборлолтыг оруулаагүй болно) байгаа боловч алтны хайгуулын ажлаар тогтоогдсон нөөц нь 1,600 тн байгаа нь ойрын ирээдүйд томоохон уул уурхайн компаниудаас гадна бичил уурхай эрхлэгчдийн хувьд олборлолт явуулах боломж байна гэдэг нь харагдаж байна.

Тус орон уул уурхайн 130 гаруй компани хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа эрхлэж байгаа бөгөөд нийт 20,000 хүн ажиллаж байна. Эдгээр албан ёсны уул уурхайн компаниудаас гадна зуданд малаа алдсан хөдөөгийн малчин иргэд амжиргаагаа залгуулах орлогын эх үүсвэр бий болгох үүднээс албан бусаар олборлолт явуулж байна. Албан бус мэдээгээр Монгол улсад албан бусаар олборлолт эрхлэж буй хүмүүсийн тоо 100,000 хүрээд байна.

3.3. Нийгмийн асуудал

1990-ээд оны эхэнд Монгол оронд социалист тогтолцоо задран унаж, чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжих болсон цагаас эхлэн эдийн засаг бага зэрэг өсөлттэй байсан ч улс орны хэмжээнд ядуурал (нийт хүн амын 36.1%), ажилгүйдэл (14.1 %) газар авч, ард иргэдийн амьжиргааны түвшин нийтдээ буурсан. Орлогын эх үүсвэр, ажлын байр хомсдож, үйлдвэрийн газрууд зогссон нь зөвхөн амьжиргаагаа залгуулах стратегийг барих болсон нь “нийтийн” гэгдэж байсан байгалийн нөөцөө ямар ч хяналт, тооцоогүйгээр ашиглах болсны хариуд байгаль орчны доройтол түүний дотор ялангуяа бэлчээрийн талхагдал, биологийн төрөл зүйл ба газрын доройтол, усны бохирдол, ландшафтын эвдрэл сүйрлийг бий болгоод байна.

3.4. Байгаль орчны байдал

Монгол оронд байгаль орчны менежментийн асуудал нэлээд орхигдсон байгаа өнөө үед (биологийн төрөл зүйлийн хомсдол, экосистемийн доройтол бий болж, байгаль орчны асуудал дэлхийн зах зээлийн өрсөлдөөн, эдийн засгийн хөгжлийн асуудалтай эн зэрэгцэх болсон өнөө үед) үнэлгээний баг улс орны эдийн засгийг бэхжүүлж, ард иргэд ялангуяа эмзэг, ядуу хэсэгт чиглэн, байгаа боломж, нөхцлөө ашиглан асуудлуудыг цогцоор авч үзэхэд анхаарлаа хандуулах хэрэгтэй гэсэн дүгнэлт гаргасан. Үүний тулд Бичил уурхайн салбарыг хөгжүүлж, энэ талаар өмнөд Америкийн зарим орнуудад ШХХАА, Дэлхий нийтийн байгаль орчны хөтөлбөрийн хүрээнд 10 гаруй жил

хэрэгжүүлсэн үйл ажиллагааны туршлагаас суралцан нэвтрүүлэх хэрэгтэй гэсэн шийдвэр гаргасан.

3.5. Бүтэц зохион байгуулалт

Монгол улсад эрдэс баялагийн нөөцийн менежментийн асуудлуудыг хариуцан зохицуулдаг байгууллага бол тус улсын Үйлдвэр худалдааны яамны дэргэдэх Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар (АМГТХЭГ) юм. Тус агентлаг нь хэдийгээр лизенцийн хураамж төлбөрөөс нэлээд орлого олж чаддаг ч үйл ажиллагаагаа ялангуяа Бичил уурхайн салбарын үйл ажиллагааг зохицуулах талаар хөрөнгө санхүү, нөөцөөр дутагдалтай байдаг. Хөдөөгийн хөгжил сул. Хөдөө орон нутагт сум, аймгийн засаг захиргаад нь байгалийн нөөцийн менежментэд гол чухал үүрэг гүйцэтгэдэг ч хөрөнгө санхүү, нөөц чадавхийн хувьд мөн дутагдалтай байдаг. Хөдөө орон нутагт байгаль орчны асуудлыг Улсын мэргэжлийн хяналтын газрын удирдлага дор ажилладаг сумдын байгаль орчны байцаагчид үндсэндээ хариуцаж ажилладаг.

3.6. Бодлого зохицуулалт

Одоогоор улс төрийн байдал нааштайгаар эргэж, бичил уурхай эрхлэгчдийг дэмжин туслах, Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, бичил уурхай эрхлэгчдийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх үүднээс хуулийн шинэ төсөл боловсруулах, тэдний амьжиргааг сайжруулах талаар нэлээд өргөн хүрээтэй Улсын их хурал, засгийн газрын хуралдаан дээр ярилцаж, албан ба албан бус олборлолтын хооронд гардаг олборлолтыг эвээр зохицуулах арга хэмжээ авч байна.

4. Мянганы хөгжлийн зорилго, ядуурлыг бууруулахад чиглэсэн өнөөгийн үйл ажиллагаатай уялдуулан хөгжлийн бодлогын хувьд холбогдох байдал

Дээрх нөхцөл байдлыг авч үзээд улс орны хөгжлийн бодлого, стратегийн чиг баримжаа/удирдамжийг нийгмийн ядуу хэсгийг дэмжих, амьжиргааны тогтвортой байдлыг хангахад чиглүүлэн боловсруулсан. Энэ зорилгод хүрэх гол арга зам бол байгалийн нөөцийн тогтвортой/зүй зохистой ашиглалтыг хангах явдал юм. Эдийн засгийн хөгжил ба ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг, Мянганы хөгжлийн зорилтууд, Засгийн газрын хөтөлбөр зэрэг үндэсний баримт бичгүүдэд стратегийн гол чиг хандлагыг нэгэн адил тодорхойлсон.

Эдгээр нөхцөл байдалд үндэслэн ШХХАА-ын дунд хугацааны зорилго нь тус орны ядуу ба эмзэг бүлгийн хүмүүсийн амьжиргааг дээшлүүлж тогтвортой байлгахад тусламж дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ. ШХХАА нь байгалийн гамшигт нэрвэгдэгсэд ялангуяа ядуу ба эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх тусламж дэмжлэгээ засаглал, чадавхийг бий болгох, хөдөөгийн иргэдийн дунд орлогын эх үүсвэр бий болгох, байгалийн нөөцийн менежментийн

асуудлуудад голлон анхаарсан хөгжлийн үйл ажиллагаатай хослуулан хүргэж байна.

2004 онд ШХХАА-ны төв удирдах байгууллага Дэлхий нийтийн байгаль орчны хамгааллын хөтөлбөрөөс Монгол улсад нэг жилд 1 сая швейцари франкийн санхүүжилт бүхий байгалийн нөөцийн менежментийн төсөл хэрэгжүүлэх шийдвэр гаргасан.

4.1. Монгол улсын Бичил уурхай эрхлэгчид болон Өмнөд Америкийн Бичил уурхай эрхлэгчдийн хоорондын ялгаа

Сүүлийн 10 жилийн хугацаанд Бичил уурхай эрхлэгчдийн талаар олон төрлийн байгууллагууд (Канадын олон улсын хөгжлийн агентлаг, CASM, Олон улсын хөдөлмөрийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны агенглаг, Америкийн олон улсын хөгжлийн агенглаг, Дэлхийн банк, Данийн геологийн алба г.м.) судалгаа хийж байна. Олон улсын хөдөлмөрийн газар болон Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөрийн төслөөс бусад нь Бичил уурхай эрхлэгчдэд тусламж дэмжлэг үзүүлэх талаар ямар нэг арга хэмжээ авах талаар тодорхой ажил хийгдээгүй байна. Харин бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааг макро- болон нийгэм -эдийн засгийн талаас нь авч үзвэл маш чухал үүрэг гүйцэтгэдэг гэдэг нь эргэлзээгүй тодорхой бодит үнэн юм. Доорх хүснэгтэд тоон үзүүлэлтүүдийг харуулав.

Бичил уурхай эрхлэгчдийн тоо	50,000-100,000
Бичил уурхай эрхлэгчдийн жилд олборлодог алт	5-10тн
Жилийн үйлдвэрлэл борлуулалтаар	60.0-120.0 сая ам. долл.
2003 оны ноолууранэдлэлийн борлуулалт (жишиг)	36.5 сая ам. долл.

Монгол улсын бичил уурхай эрхлэгчдийн хэрэглэж буй багаж хэрэгсэл, олборлолтын арга барил нь Өмнөд Америкийн бичил уурхайн эрхлэгчдийн хэрэглэдэг багаж хэрэгсэлтэй ерөнхийдөө адил юм. Гэсэн хэдий ч зарим нэг тодорхой зүйл дээр ялгаа ажиглагддаг²:

Бичил уурхайн үйл ажиллагаа нь саяхан шинээр бий болсон бөгөөд өмнө нь үйл ажиллагаа эрхэлж байсан уламжлал, туршлага бага. Бичил уурхайн үйл ажиллагаа нь 1991 онд Бороо голын орд дээр алт ялгах үйлдвэрт (мөнгөн ус ба алт) эхэлж, түүний дараагаар Бороогийн үндсэн ордуудад тархан (1996) 1997 оноос шороон ордуудад мөн 1999-2002 оны зуднаар малаа алдсан малчид бичил уурхайн үйл ажиллагаанд оролцох болсон.

Цөөн тооны бие даасан "мэргэжлийн" уурхайчид байдаг. Бусад орнуудад уурхайчдын мэргэжил нь урт удаан хугацааны турш өвлөгдөн залгамжлагдаж аж амьдралынх нь үндсэн хэрэгсэл байдаг бол Монголын

² Дэлхийн банкнаас Бичил уурхай эрхлэгчдийн талаар хийсэн судалгаа (Жеффри Дависон)

бичил уурхай эрхлэгчдийн хувьд тийм биш. Тэд сонголтоор бус, харин амьдралын шаардлагаар энэ үйл ажиллагаан орсон хүмүүс байдаг.

Шороон орд бүхий газруудад үүсмэл орд бий болдог бөгөөд энэ нь үйлдвэрлэлийн аргаар олборлох боломжгүй хаягдал нөөц юм.

Ихэвчлэн лицензтэй болон ашиглагдаж байгаа талбай дээр бөөгнөрч үйл ажиллагаагаа явуулдаг. Бичил уурхай эрхлэгчид нь гол төлөв уул уурхайн компаниудын худалдаж авсан талбай дээр мөн түүнчлэн уулын ажлын талбай дотор үйл ажиллагаагаа явуулдаг. Сүүлийн үед шинээр орд гэгдэж байгаатай холбогдон уг нөхцөл байдал өөрчлөгдөх төлөвтэй байгаа.

Төрөөс ашиглагсан талбайд үйл ажиллагаа явуулахыг хязгаарлаж байна. Байгаль орчныг дахин эвдрэлд оруулахгүй, ирээдүйд үйлдвэрлэлийн ач холбогдолтой болох магадлалтай нөөцийг хадгалах зорилгоор Засгийн газраас ашиглагдсан талбайд гар аргаар олборлолт хийх үйл ажиллагааг зогсоох оролдлого хийж байна.

Монголд бичил уурхай эрхлэгчид нь үйлдвэрлэлийн олборлолтыг байнга дагалдаж байдаг. Уул уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаа бараг бүх газруудад үйлдвэрлэлийн олборлолт нь бичил уурхай эрхлэгчдийн өмнө нь явагддаг. Бусад орнуудад байдал эсрэгээрээ байдаг: томоохон үйлдвэрлэгч нар нь гол төлөв бичил уурхай эрхлэгчдийг дагаж явсны үндсэн дээр үнэ цэнэ бүхий ирээдүйтэй орд газруудаа олж авдаг. Харин энэ хандлага өнөө үед Говийн бүс нутагт өөрчлөгдөх хандлагатай байна.

Жилийн дөрвөн улирал: Шороон болон үндсэн ордууд дээр жилийн турш үйл ажиллагаа явуулдаг хэдий ч ид олборлолт нь зуны улиралд хийгддэг.

Олон зорилго, олон үр дүн — ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох: Маш богино хугацаанд энэхүү үйл ажиллагаа нь хот суурин болон хөдөө орон нутагт ядуурлыг бууруулах чухал хүчин з үйл болж байгаагаас гадна суурьшмал байдалтай хөдөө аж ахуйн нэгдлүүдийн оршин тогтнох үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь болж байна; бага оврын олборлолт нь уул уурхайн болон илүү алслагдмал бүс нутгуудад ашгийн төлөөх хөдөлмөр эрхлэлт болон бага оврын олборлох үйл ажиллагааг бий болгож орон нутгийн хүүхэд залуучуудыг сурч боловсроход нь санхүүгийн маш чухал дэмжлэг болох үүрэгтэй юм. Мөн уул уурхайн бүс нутгийн эдийн засаг болон нийгмийн чухал салбаруудад нөлөөлөх нь тодорхой юм.

Гэр бүлийн хүчин зүйл. Гар аргаар олборлолт явагдаж байгаа ихэнх газруудад ажил, нийгмийн зохион байгуулалт болон харилцан үйл ажиллагаа явуулах зарчмуудыг гэр бүлээр зохицуулдаг. Ажлын бригадууд ихэнхдээ нэг гэр бүлийн хүмүүсээс бүрдэх бөгөөд жилийн улирлаас хамааран хүүхдүүд нь ч олборлолтын үйл ажиллагаанд оролцоно. Үйлдвэрлэлийг гэр бүлийн зарчим дээр үндэслэснээр тухайн аж ахуйн нэгж нь нийгэм болон эдийн засгийн тогтвортой байдалд оршиж ажлын зохион байгуулалт нэг гарт төвлөрснөөр гэр бүлийн аюулгүй байдал, эдийн засгийн боломж дээшлэнэ. Ингэснээр тухайн гэр бүлийн бүх гишүүд үйлдвэрлэлд оролцсоноос үл хамааран хангалуун амьдрах боломжтой болно.

Нөхцөл байдалд уусан дасах, шинийг сэдэх, шинэ санаануудыг нэгтгэх чадвар. Уул уурхайн салбарт хүчээ сорихоор ирж байгаа хүмүүс нь өөрчлөгдөж буй нөхцөл байдалд уусан дасах, өөрсдийнх нь хөдөлмөрийн

бүтээмжийг дээшлүүлэх магадлалтай гэсэн шинэ санаануудыг хэрэглэн турших, өөрсдийг нь үйлдвэрлэлийг хязгаарлаж магадгүй гэсэн хүндрэлүүдийг түргэн шуурхай шийдвэрлэх чадвартай байдаг нь маш сонин бөгөөд гайхал төрүүлэм байдаг.

Хүүхэд залуучуудыг мөнгөн устай харьцуулдаг. Мөнгөн усыг ихэнхдээ тоосонцор алт ялгаж авах зорилгоор үндсэн ордууд дээр хэрэглэдэг тул уг туршлага хязгаарлагдмал хэрэглээтэй байдаг. Алтыг мөнгөн усаар угаах процесст залуучууд ихээхэн оролцдог бөгөөд хольцыг шарах үйлдэлд бүр хүүхдүүд хүртэл оролцдог. Хэрэв хольцыг шарах процессийг буруу үйлдвэл тухайн хүүхэд мөнгөн усны ууранд цохиулах аюулд өртөнө.

Гар аргаар олборлогч нарыг байнга айлган сүрдүүлж, тэдний эсрэг хүч хэрэглэдэг. Энэ ажлуудыг ихэнхдээ хувийн хөлсний хамгаалалтын байгууллагууд хийж гүйцэтгэдэг бөгөөд тэдний гол зорилго нь хөлслөгч компанийн өмч хөрөнгийг хамгаалахад оршино. Энэ хамгаалах үйл ажиллагаа нь лицензийн талбайн гадна байсан ч хамаагүй гар аргаар олборлогч нарыг хэл амаар доромжлох, эрх чөлөөнд нь халдах, тэдний эд хогшлыг эвдэж хэмхлэх, алтыг нь хураах ажил болон хувирч байна. Энэ нөхцөл байдал улам даамжирсаар байна.

4.2. Монголын бичил уурхай эрхлэгчдийн талаарх мэдээлэл

Дээр дурьдсан ёсоор сүүлийн 10 жилийн хугацаанд нинжа нарын талаар маш олон байгууллагууд олон тооны судалгаа хийсэн байдаг.

4.2.1. Чухал холбогдох баримт бичгүүдийн жагсаалт

Д/д	Баримтын нэр	Зохиогч	Санхүүжүүлэгч
1	Монголын уул уурхайн салбар: Ирээдүйн төлөв (2004)	Husband, Songwe, Davidson	Дэлхийн Банк
2	Уул уурхайн салбар дахь хүүхдийн хөдөлмөрийг устгах ILO/IPEC хөтөлбөрийн дунд шатны үнэлгээ (2001)		ILO/IPEC (Олон улсын хөдөлмөрийн газар/ Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр)
3	Монгол: Гар аргаар олборлох үйл ажиллагаа ба хүүхдийн хөдөлмөр. Вашингтонд болсон Орон нутгийнхан болон бага оврын уулын үйлдвэрлэл сэдэвт семинарт тавьсан илтгэл (2004)	Монголмаа	ILO/IPEC
4	Монголд хүүхдийн хөдөлмөрийг устгах ILO/IPEC-ийн төслийн тооцоо. 1-р үе шат (2001 оны 11-р сар)	Aschmoneit, Мөнхжаргал	ILO/IPEC
5	Монголын бага оврын уулын үйлдвэрлэл – 2004 онд хийж гүйцэтгэсэн судалгаа	Peter W. Uitterdijk Appel	Данийн геологийн алба
6	Монгол дахь гар аргаар олборлох үйл ажиллагаа (2003 оны 4-р сар)	Murray & Grayson	Канадын сан
7	Монголын алт олборлогч бичил уурхай эрхлэгчид (2003/9)	MDBA, Eco-minex, Murray-Harrison Ltd (Robin Grayson)	Канадын сан

8	Шри Ланкад болсон Орон нутгийнхан болон бага оврын уулын үйлдвэрлэл сэдэвт семинарт тавьсан илтгэл (2004)	Дэлгэрцоо	CASM (Орон нутгийнхан болон бага оврын уулын үйлдвэрлэл)
9	Шри Ланкад болсон Орон нутгийнхан болон бага оврын уулын үйлдвэрлэл сэдэвт семинарт тавьсан илтгэл (2004)	Баатар	CASM
10	Шри Ланкад болсон Орон нутгийнхан болон бага оврын уулын үйлдвэрлэл сэдэвт семинарт тавьсан илтгэл (2004)	Peter Appel	CASM
11	Гар аргаар олборлогч нарын тухай хууль	Монголын ЗГ	
12	Ашигт малтмалын тухай хууль	Монголын ЗГ	
13	Хууль бус олборлолтыг зохицуулах эрх зүйн актууд	Монголын ЗГ	
14	Бороогийн бүс нутаг дахь мөнгөн усны бохирдлын судалгаа (2005)	Түмэнбаяр	JICA
15	Mongolia: Exploring Next Mineral Frontier (2005)	ЗГ/АМГТХЭГ	
16	Монголын уул уурхайн салбарт баримтлах байгаль орчин болон нийгмийн бодлого, туршлага (2003/10)	Rheinbraun Engineering; Ruhrmann, Becker	Дэлхийн банк
17	Монголын уул уурхайн салбарын өрсөлдөх чадвар ба тогтвортой гэрээг ашиглах нь (2004/4)	William Arnold	(USAID) Америкийн олон улсын хөгжлийн агентлаг
18	Заамар дахь гар аргаар олборлогч нарын амьдралын нөхцөл (2005)	Mohamed Nawaz	Fredskorpset

4.3. Бичил уурхай эрхлэгчдийн олборлолтоос үүдэх бусад хэлбэрийн үйл ажиллагаа

Өнөөг хүртэл бичил уурхай эрхлэгчдийн асуудлыг өргөн хүрээтэйгээр дорвитой шийдвэрлэх арга хэмжээг ямар ч байгууллага хийж гүйцэтгээгүй байна. Дараах хүснэгтэд тусламжийн үйл ажиллагаа болон төлөвлөсөн ажлуудыг нэгтгэн үзүүлэв.

Дэмжлэг үзүүлэх байгууллага	Уул уурхайн салбарт хамгийн сүүлд нэвтрүүлсэн шинэчлэл	Уул уурхайн салбарт нэвтрүүлэх шинэ арга хэмжээнүүд
SDC (Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны агентлаг)	бичил уурхай эрхлэгчдийн талаар уулзалт зохион байгуулж Монгол хэл дээр нинжа нартай холбогдох бичиг баримтуудыг бүрдүүлэн бэлтгэж төсөл хэрэгжүүлэх боломжийг үнэлсэн	Байгалийн баялгийг зөв зохистой хуваарилах төсөл боловсруулж уг төсөлд бичил уурхай эрхлэгчид орон нутгийг хөгжүүлэх үндсэн хөшүүрэг болох, үүнээс үүдэн амьдралын түвшин сайжрах
BGR (Германы геологийн алба)	Гар аргаар болон бага оврын уулын үйлдвэрлэлийг хамаарсан төсөл шаардлагатайг анх үнэлсэн	2005 оны 8 сараас улсын хяналтын албатай хамтарч уурхайн хяналтын ажилд тусламж дэмжлэг үзүүлэх төсөл эхлэх. Хүрээлэн буй орчны нөхцөл байдлыг тооцсон үйлдвэрлэлийн төсөл хийгдэх судалгаа 2005/6 сард гүйцэтгэх
GTZ	Гар аргаар олборлогч нарын тухай	Үйл ажиллагааг зохицуулах

	чуулга уулзалтыг хамтарч санхүүжүүлсэн	буюу гар аргаар олборлогч нарын салбарт ажиллах сонирхолтой: бодлого болон үйл ажиллагааны бүс нутгаа хараахан сонгоогүй
GEUS (Данийн геологийн алба)	Говь болон хойт Монголд бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа байгаль орчинд хэрхэн нөлөөлж буйг судалсан: хоёр төслийн санал дэвшүүлсэн;судалгааны ажлын явцад реторт хэрхэн ашиглах талаар сургалт явуулж байсан	Хоёр төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө (нэг нь Бороо голын хаягдлын талбайг цэвэрлэх, нөгөө нь нинжа нарт ретортыг хэрхэн хэрэглэх талаар сургалт явуулах)
ILO/IPEC	Монголын ажил олгогчдын холбоотой хамтарч нүүрс болон алтны салбарт хүүхдийн хөдөлмөрийг устгах төслийн тодорхой үе шатуудыг хийж гүйцэтгэсэн	Уул уурхайн салбарт хүүхдийн хөдөлмөр ашиглах явдлыг устгах үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх
Канадын	Монголд анх бичил уурхай эрхлэгчдийн талаар хийсэн нарийвчилсан судалгааг санхүүжүүлсэн (гүйцэтгэгч нь Robin Grayson)	Цаашдын үйл ажиллагаа тодорхойгүй
JICA	Мөнгөн усны бохирдол, уурхайчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн хордолтыг судлах байгаль орчны судалгаа	Цаашдын үйл ажиллагаа тодорхойгүй
Дэлхийн банк	Монголын уул уурхайн салбарын судалгаа нэгтгэн дараах тайланд дүгнэсэн: Монголын уул уурхайн салбар: ирээдүйн төлөвлөлт. Тайланд Jeffrey Davidson-ы бичил уурхай эрхлэгчдийн тухай хийсэн судалгаа нэг бүлэг нь болж орсон	Цаашдын үйл ажиллагаа тодорхойгүй
АНУ-ын элчин сайдын яам	АНУ-ын олон улсын хөгжлийн байгууллага нь Монголын уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг судалсан	АНУ-ын ЭСЯ нь бичил уурхай эрхлэгчид мөнгөн ус хэрэглэж байгаа явдалд арга хэмжээ авах зорилгоор USEPA-ийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх сонирхолтой байгаа (тодорхойгүй)
BMBF (Боловсрол судалгааны холбооны яам, Герман)	Германы Касселийн Их сургуулийн Усны нөөцийн судалгаа ба менежментийн сургууль болон Монгол улсын Их сургуулийн хамтарсан Зүүн-хойд Монгол дахь уул уурхайн салбарын байгаль орчинд нөлөөлж байгаа сөрөг нөлөөллийн талаарх эрдэм шинжилгээний судалгааны төсөл, хамтын ажиллагаа	Судалгааны ажил 2006 оны төгсгөл хүртэл үргэлжлэх бөгөөд судалгааны үр дүнг тараах, хяналт, менежментийн туршилтын ажлууд хийж гүйцэтгэгдэнэ.
Konrad-Adenauer-ийн сан	Том оврын уурхайнуудын эсрэг нэгдлийн зарчим дээр суурилагдсан байгууллагуудыг байгуулах	Хөдөө орон нутаг болон уул уурхайн бүс нутгуудтай холбоотой ардчиллын зарчим дээр үндэслэгдэх байгууллагуудыг байгуулах
Норвегийн ЗГ	Заамарын бүс нутаг дахь нинжа нарын нийгэм эдийн засаг болон соёл ахуйн судалгааны ажлыг санхүүжүүлсэн	Цаашдын үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй
Дэлхийн Зөн (World Vision)	Нинжа нарыг хүрз, хямд төсөр багаж хэрэгсэл зэргээр хангах ажлыг	

	санхүүжүүлсэн	
Халифакс дахь Гэгээн Мэригийн их сургууль		Геологийн хүрээлэнтэй хамтарч бага оврын олборлогч нарын мэргэжил дээшлүүлэхэд зориулж багш нарыг бэлтгэх, 2004-2009

5. Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны агентлагийн дэмжлэгээр хэрэгжүүлэх төслийн агуулга

6.1. Төслийн үйл ажиллагааны тойм

6.1. Хамтрагч талуудын чуулга уулзалтын үр дүн

“Байгалийн баялгийг зөв зохистой хуваарилах ажлын хүрээн дэх бага оврын уулын үйлдвэрлэлийн хэмжээг үнэлэх” ажлын явцад 2005 оны 4-р сарын 29-нд Улаанбаатар хотын Чингис хаан зочид буудалд хамтрагч талуудын чуулга уулзалт зохион байгуулав. Чуулга уулзалтад 100 орчим хүн оролцсон.

Өмнөд Америкт хэрэгжүүлсэн төслүүдийн туршлагыг (гол анхаарлыг хууль эрх зүй болон байгаль орчны менежмент дээр төвлөрүүлсэн) танилцуулсны дараа Монголын ирээдүйн төлөв байдлыг танилцуулав. Танилцуулгын ажлын агуулгаас хамаарч ажлын дөрвөн баг бүрдүүлсэн бөгөөд баг бүр өөрийн асуудал, боломжийн шийдэл болон Өмнөд Америкийн туршлагыг хэрэгжүүлж болохуйц хувилбаруудыг судалсан юм.

6.2. Тулгамдаж буй асуудлуудад хийсэн дүн шинжилгээ

Ажлын хэсгийн үйл ажиллагааны үр дүн, мөн газар дээр очиж нөхцөл байдалтай танилцан хамтрагч талуудтай уулзсаны үр дүнд тулгуурлан нинжа нарын асуудлын зангилааг тодорхойлов. Орон нутгийн тогтвортой хөгжилд нинжа нарын оруулж байгаа хувь нэмрийг буруулж байгаа үндсэн асуудлыг олж тогтоосон. Энэ нь дараах хүчин зүйлсээс шалтгаалж байна. Үүнд:

1. Одоогийн байдлаар Монгол улсын Засгийн газар нинжа нарын үйл ажиллагааг зөв зохистой удирдаж чадахгүй байна (мэдлэг, туршлага хараахан эзэмшээгүй, зөв зохистой менежмент бүрдүүлэх зохион байгуулалтын бүтэц байхгүй, хууль эрх зүйн болон бодлогын хөшүүргүүд байхгүй).
2. Одоогоор ажиглагдаж байгаа гар аргаар олборлох үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж нийгмийн уур амьсгалд муугаар нөлөөлж байна. Үүнд байнгын хэрүүл тэмцэл үүсэхээс гадна бичил уурхай эрхлэгчид болон тэдний гэр бүлийнхэн маш хүнд нөхцөлд амьдарч байна (хэрэглэж байгаа техник нь бүтээмж муутай, бичил уурхай эрхлэгчид нь хууль бус үйл ажиллагаа явуулдаг г.м.).
3. Нинжа нарын үйл ажиллагаа ирээдүйгүй гэсэн уур амьсгал олон нийтийн дунд тархсан байдаг.

6.3. Үнэлгээний багийн ажлын явцад ба тус багийн дүгнэлт гарсны дараа үед хийгдсэн/авагдсан арга хэмжээнүүд

Бэлтгэл ажлыг хангах үүднээс дараах арга хэмжээнүүдийг авав. Үүнд:

- Монголын болон Швейцарийн хамтрагч нартай тусламжийн төслийн саналыг боловсруулсан.
- 5-р сарын 13-нд АШГТХЭГ-т болох уулзалт дээр төслийн саналыг холбогдох яам, засгийн газрын хүмүүст танилцуулж, батлуулах,
- АМГТХЭГ дээр бичил уурхай эрхлэгчдийн асуудлыг зохицуулах бичил уурхайн нэгжийг байгуулж эхлээд байна.
- Монголын оролцогч түншүүдэд гар аргаар олборлох тухай хуулийн төслийг танилцуулан тайлбар өгч, Перуд баталсан гар аргаар олборлох тухай хуулийг монгол хэл дээр хөрвүүлэн бэлдэж бага оврын үйлдвэрлэлийн нөөц бололцооны талаар танилцуулах мэдээ бэлдсэн (Монгол хэл дээр товхимол болгон хэвлүүлсэн)
- Эхний үе шатны ажлын төлөвлөгөөг Берн дэх ШХХАА болон Монгол дахь ШХХАА-ийн багууд дээр боловсруулж Берн дэх ШХХАА-т танилцуулан батлуулсан
- Монголд байгалийн баялгийг зөв зохистой хуваарилах төсөлд дэмжлэг үзүүлэх Швейцарийн засгийн газрын шийдвэрийг эхний үе шатны санал дээр үндэслэн баталсан
- Эхний үе шатыг хэрэгжүүлэх ажилд Германы консалтингийн Projekt-Consult GmbH компанийг томилсон,
- Эхний үе шатыг 2005 оны 7-р сарын 1-ээс эхлэхээр тогтож санхүүжилтийг батлав.

6.4. Латин Америкт ШХХАА-ийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн төслүүдийн туршлагыг ашиглаж болох талаар

Ийм төрлийн төслийг хэрэгжүүлэхэд ШХХАА-т дэвшүүлж болохуйц маш их санал байна:

- ШХХАА нь байгаль орчинтой холбоотой өөрийн бүх мэдлэг туршлага, өөрийн үүрэг болон дэмжлэлгийг (хүн хүчний, материалын болон санхүүгийн) урт удаан хугацааны турш үзүүлэхэд бэлэн байна
- ШХХАА нь Монголын ЗГ болон бусад тусламжийн хөтөлбөрт оролцож буй байгууллагуудтай маш дотно харьцаатай ажиллахад бэлэн байна
- ШХХАА нь Эквадор, Перу болон Боливиийн гар аргаар олборлогч нарт тусламж үзүүлсэн 12 жилийн турш хуримтлуулсан туршлагаасаа хуваалцахад бэлэн байна.
- ШХХАА нь цаашид ч мөн бага оврын уулын үйлдвэрлэлд хамрагдах үндсэн нэгж, хувь хүмүүстэй холбоо тогтоон хамтарч ажиллахад бэлэн байна.

Доорх хүснэгтэд Латин Америкт хэрэгжүүлсэн төслийн туршлагыг Монголын төсөлд хэрэгжүүлэх ажлуудтай нийцүүлэн нэгтгэв.


	Хамаарах бүрдлүүд/механизмууд	Төсөлд нэвтрүүлэх хэлбэр
Бага оврын уулын үйлдвэрлэлийн (БОУУ) хууль эрх зүйн актууд (хууль, журам)	- хууль төслийг олон талын оролцогч нарын санал солилцооны үндсэн дээр боловсруулах - Латин Америкийн туршлагуудыг БОУУ-ийн хууль эрх зүйн актуудтай харьцуулан үнэлэх - Батлан мөрдөж буй хуулийг жишээ болгон үзэх - журмуудыг судлах	Перугийн хууль эрх зүйн бичиг баримтыг Монгол хэлэнд хөрвүүлж тайлбар өгөх
Хууль эрх зүйн акт бүрдүүлэх ажлууд	БОУУ хариуцсан байгууллагуудын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны эрх зүйн актуудыг боловсруулах ажилд үзүүлэх туслалцааг шат шатаар хэрэгжүүлэх	Ийм төрлийн туслалцаа хийгдэж байсан
Зөрчилдөөнийг зохицуулах	- зөрчилдөөнийг зохицуулах аргачлал - Том оврын уулын үйлдвэр, бага оврын үйлдвэрлэгч хооронд гэрээ хэлэлцээр байгуулах	БОУУ-ийн олон талт хууль эрх зүйн актуудыг боловсруулах шинжээч нарыг оролцуулах
Байгаль орчны менежмент	- харьцангуй их хэмжээний олборлолттой бөгөөд байгаль орчинд мэдэгдэхүйц нөлөөлж байгаа үйлдвэрлэлд байгаль орчны менежментийн энгийн жишээ байдлаар ЕСО+ төлөвлөгөөг хэрэгжүүлэх - салангид буюу жижиг олборлогч нарт Байгаль орчны дасан зохицох (адаптации) болон менежментийн төлөвлөгөөг (PAMAs) хэрэгжүүлэх	Өмнөд Америкийн БОУУ-ийн байгаль орчны менежментийн туршлагаас судлан тохиромжтой механизмуудын талаар хамтрагч талуудтай санал солилцох (АМГТХЭГ, БОЯ, Улсын мэргэжилтний хяналтын газар г.м.)
БОУУ-д хэрэглэгдэх технологи, байгаль орчныг хамгаалах технологи	- ялгалт өндөртэй бөгөөд бага зардалтай уламжлалт техник технологийн өргөн сонголт (бусад орнуудад үйлдвэрлэгдсэн) - орчны бохирдол ихтэй баяжуулах үйлдвэрүүдийг (мөнгөн устай холбоотой хүндрэлүүд) цэвэр бөгөөд өндөр бүтээлтэй ажиллах үйлдвэр болгон шинэчлэх өргөн туршлага	Боливийн металлургийн шинжээчдээр туршилтын арга хэмжээнүүд төлөвлүүлэх, Монголд тохирох болон цаашдаа Монголд хувилж болохуйц БОУУ-ийн технологийг боловсруулах мэргэжилтнүүдийг урьж авчрарх
БОУУ-ийг хариуцах удирдлагыг орон нутагт байршуулах	- Орон нутгийн засаг захиргаанд уул уурхай хариуцсан алба байгуулж тэдэнд зааварчлага өгч олборлолтын үйлдвэрлэлд идэвхитэй оролцуулах, - сургалт адлагын ажил явуулах - харилцааны олон талт хэрэгсэл хэлбэрээр дэд төсөл-хяналтын үйл ажиллагаа явуулах	
Харилцан холбоо үүсгэх	Перу дахь БОУУ-ийн талаарх	Монголд мэдээллийн болон өмгөөллийн сан

замаар олон нийтэд зөв ойлголт төрүүлэх	- мэдээллийн компьютержсэн сан - Перуд одоогоор 300 гаруй олборлогч нарын талаарх мэдээллийг өдөр тутмын хэвлэлд нийтэлдэг	байгуулахад тусламж дэмжлэг үзүүлэх
Үйлчилгээгээр хангагч нарын мэргэжлийг дээшлүүлэх	байгаль орчны хянагч нарыг сургах; хувийн болон засгийн газрын бус зохион байгуулалттай үйлчилгээ үзүүлэгч нарт дэд төсөл биелүүлэх эрх үүргийг шилжүүлэх	
Сургалт, сургалтын материалууд	Сургалтын материал боловсруулагч нар (сургалтын төлөвлөгөө, текстүүд, үзүүлэн г.м.)	Сургалтын материал боловсруулахад Болив болон Перугийн туршлагыг ашиглах
Нийгмийн нэмэлт үйлчилгээ	уул уурхайн нийгэмлэгүүдийн хүүхдийн сургуулиудыг хүнсээр хангах үйлчилгээ	

Цаашдаа ШХХАА-ийн дэмжлэгээр хэрэгжүүлж буй төслүүд болон CASM/Дэлхийн банкид зөвлөмж өгөх гүйцэтгэлийн явцад туршлага (ноу-хау) дамжуулах нэмэлт аргууд боловсрогдох болно.

6.5. Асуудлыг судлах ажлын ерөнхий бүтэц

ШХХАА (SDC) нь Байгалийн баялгийг зөв зохистой хуваарилах төслийг хэрэгжүүлэхэд Монгол улсад туслалцаа үзүүлэхээр болсон юм. Энэхүү төсөл нь Монголын үндсэн хамтрагч талуудад дэмжлэг болох зорилготой бөгөөд тэдгээрийн ашигт малтмалыг олборлох үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөнд бүрэн нийцэж хөдөө орон нутгийн



амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн байх болно. Төслийн дараагийн үе шатанд ойн аж ахуй, хэмнэлттэй эрчим хүч г.м. өөр салбаруудын үйл ажиллагаа хамрагдах боломжтой. Төслийн эхний үе шатанд нинжа нарын үйл ажиллагаа хамрагдах бөгөөд уг салбар нь дараачийн судалгааны сэдвийг нээх боломжтой юм.

Монголын Байгалийн баялгийг зөв зохистой хуваарилах төслийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох хэлбэрээр дэмжлэг

тусалцаа үзүүлэх шийдвэрийг Швейцарийн байгаль орчны хөтөлбөрийн хүрээнд баталсан болно.

Бичил уурхайн үйл ажиллагааг орон нутгийг хөгжүүлэх үндсэн хэрэгсэл болгох боломж мөн уг салбарыг хөгжүүлснээр амьдралын түвшин тогтвортой дээшлэх гэсэн бодлогыг баталгаажуулах үүднээс дараах туршлагуудыг

ишлэл болгон хэрэглэв: (1) сүүлийн 10 жилийн хугацаанд дэлхийн өнцөг булан бүрт CASM (Орон нутгийнхан болон бага оврын уулын үйлдвэрлэл) төслийн хүрээнд хийсэн ажлууд, мөн уул уурхай, эрдэс баялаг, тогтвортой хөгжлийн талаарх хамгийн сүүлийн үеийн санал солилцооны үр дүнгээс харахад бага оврын уулын үйлдвэрлэлийг орон нутгийн хөгжил дэвшилтэй хамт авч үзэх шаардлагатайг баталсан, (2) Латин Америкт (Эквадор, Болив, Перу) ШХХАА-ийн дэмжлэгээр гүйцэтгэсэн төслүүдийн туршлагаас харахад уурхайчид болон орон нутгийн иргэд, нийтийн байгууллагын хооронд шинэ харьцаа бүрдүүлэх, хууль бус олборлолтыг хууль ёсны болгохын тулд эрх зүй, засаг захиргааны арга хэмжээнүүдийг засаглалын бүх шатанд (үндэсний, бүс нутгийн, орон нутгийн) авч хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд (3) Монгол улсад сүүлийн жилүүдэд үүсэн бий болсон нөхцөл байдлын улмаас хамтрагч талууд нийгэм-эдийн засгийн асуудал, гарч буй зөрчлийг зохицуулах талаар олсон туршлагатаа үндэслэн арга хэмжээ авах шаардлагатай.

6.6. Төслийн зорилго

Хүндрэлтэй тулгамдаж буй асуудлуудын талаар сайн ойлголттой болох нь үйл ажиллагааны төлөвлөлтийг гаргахад тустай. Төслийн үйл ажиллагааны гол зорилго нь:

Бичил уурхайн үйл ажиллагааг байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтын хүрээнд хөдөөгийн тогтвортой хөгжлийн гол хөдөлгөгч хүч болгон хөгжүүлэхэд Монголын засгийн газарт туслахад оршино.

Төслийн үйл ажиллагаа нь дараахи үндсэн 4 зорилготой. Үүнд:

Зорилго 1: Холбогдох талуудтай хамтран ажиллаж бичил уурхайн үйл ажиллагаанд ил тод, шудрага хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, албан бус үйл ажиллагааг хууль ёсны болгоход таатай орчин бүрдүүлэх, бичил уурхай эрхлэгчдийн амьжиргааны баталгааг сайжруулах, хамтрагч талуудын эрх, үүргийг тодорхой болгоход туслах;

Шулуун шудрага хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх: төсөл нь харилцан санал бодлоо тусгаж хүлээн зөвшөөрсөн хууль, дүрэм журмыг боловсруулах, хэрэгжүүлэх, орон нутаг ба төвийн захиргаад, лизенци эзэмшигчдийн хооронд үүсдэг зөрчлийг зохицуулах арга хэмжээ авах, зөвшилцлийг бий олгоход хувь нэмэр оруулна. Түүнчлэн төсөл нь бүх хамтрагч, оролцогч талуудад үйл ажиллагаандаа дагаж мөрдөх, хэрэгжүүлэх удирдамж (хууль эрх зүйн холбоотой ажил, хяналт мониторинг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа)-ийн зарчмуудыг гаргах болно.

Бичил уурхайн үйл ажиллагааг хөдөөгийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулах: төсөл нь бичил уурхайн үйл ажиллагааг хөдөөгийн хөгжлийн асуудлуудтай уялдуулах таатай орчин бүрдүүлэхэд тусламж дэмжлэг үзүүлэх ба ингэснээр хөдөө орон нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжүүлэх ба ард иргэдийн дунд илүү баталгаатай амьжиргааг бий болгоход тус нэмэр оруулна.

Зорилго 2: Бичил уурхайн салбар ба холбогдох салбаруудын хүрээнд **бүтэц зохион байгуулалтыг бий болгох**, бүхий л түвшинд хамтын ажиллагааг хөгжүүлэх;

Бичил уурхайн салбарт бүхий л түвшинд бүтэц зохион байгуулалтыг бий болгох: төсөл нь бичил уурхайн салбарт байгаа асуудлуудыг үр ашигтайгаар шийдвэрлэхэд хувь нэмэр оруулна. Үүний тулд бүтэц зохион байгуулалтын чадавхийг бий болгох (АМГТХЭГ-ийн дэргэд Бичил уурхайн тасаг/нэгж байгуулах, олборлогчдод шаардлагатай тусламж, үйлчилгээ хүргэхэд Уул уурхайн аврах алба зэрэг байгууллагуудад тусламж дэмжлэг үзүүлэх, бичил уурхай эрхлэгчдийг зохион байгуулалтанд оруулахад туслах) бэхжүүлэх, байгууллага хоорондын хамтын ажиллагаа, холбогдох талуудын чадавхийг нэмэгдүүлэх, шинээр үүсэх зөрчлөөс урьдчилан сэргийлэх гарч буй зөрчлийг зохицуулах шийдвэрлэхэд тус нэмэр оруулах болно. АМГТХЭГ-ын удирдлага чиглэл дор бичил уурхайн үйл ажиллагааг үр ашигтайгаар зохицуулах сүлжээг бий болгож, хандивлагч ивээн тэтгэгчид, засгийн газрын байгууллагуудад бичил уурхай эрхлэгчдийн санал бодол, дуу хоолойг хүргэхэд туслах болно.

Зорилго 3: Олборлолтын үйл ажиллагааг сайжруулан аюулгүй ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлж бичил уурхай эрхлэгчид ба бусад холбогдох талуудын мэдлэг, ур чадвар, техник технологийг сайжруулах;

Амьдрал/амьжиргааны илүү баталгаатай байдал, байгалийн нөөцийг тогтвортой ашиглалтыг нэн тэргүүнд авч үзэн, бичил уурхайн үйл ажиллагааны хууль эрх зүй, эдийн засаг, байгаль орчин, техник, нийгмийн асуудлуудыг зохистойгоор шийдэхэд холбогдох талуудын дунд **чадавхийг бий болгох**;

Бичил уурхайн эрхлэгчдийн дунд нөөцийн тогтвортой ашиглалтыг бий болгон тэдний амьжиргааг сайжруулах: Холбогдох талуудын дунд хамтран ажиллах таатай уур амьсгалыг бүрдүүлсний дараа төсөл нь байгалийн нөөцийн зохистой менежмент, ашиглаж буй ордыг бүрэн гүйцэт ашиглах, олборлогчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хангах, нөхөн сэргээх ажиллагаанд гол анхаарлаа хандуулах болно. Үүний зэрэгцээ олборлогчдын мэдлэг ур чадварыг сайжруулах шинэ техник технологи нэвтрүүлж, улс орны хэмжээнд хэрэглэхэд анхаарлаа хандуулах болно. Нийгэм (жишээлбэл: ДОХ/билгийн замын халдварт өвчин гм), байгаль орчин (ус, түлш гм)-ны холбоотой асуудлаар мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулахаас гадна холбогдох байгууллагуудын дунд албан ёсны болгох сургалт, сурталчилгаа (алтыг худалдаж авахад банкны үйлчилгээг ашиглах гм)-г явуулж, бичил уурхай эрхлэгчдийн тогтвортой амьжиргааг дэмжин туслах болно.

Зорилго 4: байгалийн нөөцийн менежмент ба хөдөөгийн хөгжлийн талаар цогц мэдлэгийн суурийг бий болгох ;

Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтыг амьжиргааны баталгаа болгох: төсөл нь үйл ажиллагаагаа чиглүүлж буй газруудын байгаль орчны өнөөгийн байдал, тулгарч буй асуудлуудад үнэлгээ өгөх, байгалийн нөөцийн

менежментийг амьжиргааны олон асуудлын стратеги, хувилбар, хязгаарлалтыг авч үзсэн нийгэм эдийн засгийн урт хугацааны хөгжлийн стратегитэй уялдуулах тусгай зөвлөмж гаргахад чиглэх болно. Энэ үнэлгээ нь төслийн үйл ажиллагаа чиглэж буй газрын байгаль орчны нөхцөл байдалтай холбоотой бенчмаркийн тоо баримтыг гаргаж өгч, бичил уурхайн үйл ажиллагаа, мал маллагаа болон бусад эдийн засгийн үйл ажиллагааны хооронд харьцуулалт гаргах болно. Түүнчлэн энэ үнэлгээ нь байгаль орчноо хамгаалах нөхөн сэргээх ажлын загварыг гаргах, хөтөлбөрийн үндсэн шатны үйл ажиллагаатай уялдуулахад туслах болно.

6.7. Хүлээж буй үр дүн (гарах үр дүн, тогтвортой байдал)

Төслөөс дараахи үр дүн гарна. Үүнд:

- Төсөл нь бие даан бичил уурхайн үйл ажиллагаан дахь хүндрэлтэй асуудлуудыг шийдэж, үйл ажиллагааг хуульчлахгүй. Түүнчлэн олборлолтын албан бус байдлыг үгүй болгож, Монгол улсын хөдөөгийн хүн амын ядуурлыг үүсгээд байгаа хүчин зүйлд нөлөөлөхгүй. Харин төсөл нь холбогдох тауудыг бичил уурхайн үйл ажиллагаа дахь хүндрэлтэй асуудлуудыг зөв зохистой шийдэхэд боломж олгох/туслах болно.
- Олон талын хамтын ажиллагааг бий болгож асуудлыг шийдвэрлэнэ. Түүнчлэн үйл ажиллагаагаа (байгаль орчин, эдийн засаг, нийгмийн гэсэн 3 асуудлуудад) тогтвортой, уялдаатай явуулах ёстой. Төсөл нь үйл ажиллагааны уялдаа холбоо, зохицуулалт хийхэд туслах болно.
- Төсөл нь бие даан гол шийдвэрүүдийг гаргахгүй. Гэхдээ бичил уурхайн асуудлыг хэрхэн шийдвэрлэж буй бусад орнуудын туршлага, эдгээр орнуудад хэрэгжсэн ба хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагаа, асуудлыг шийдвэрлэж буй арга замуудаас суралцах боломж олгоно.
- Цаашид төсөл нь Монгол улсад бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаанд үндэсний ба олон улсын шинэ мэдлэг, технологийг нэвтрүүлж тэднийг чадваржуулахад бүхий л нөөц бололцоог ашиглах болно.

6.8. Хэрэгжүүлэлтийн үе шатууд:

Тус салбарыг нарийвчлан судлах үндэс суурийг бэлтгэх үүднээс 18 сар үргэлжлэх эхний үе шатыг сонгов. Энэхүү үе шат 2005 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэнэ.

6.8.1. Эхний үе шат 7/2005-12/2006: Бичил уурхайг дэмжих

Эхний үе шатын зорилгууд:

- Салбарын талаар сайн ойлголтыг бий болгох,

- Бүх түвшин (үндэсний, бүс нутгийн, орон нутаг ба түүнчлэн бичил уурхай эрхлэгчдийн хэмжээнд)-ний хамтрагч талуудын хооронд харилцан ойлголцол итгэлцлийг бий болгох,
- Ажлын төлөвлөсөн схемийг гүйцэтгэлийн үе шатанд хэрэглэж болох эсэхийг турших,
- Өмнөд-өмнөд (хөгжиж буй орнууд)-ийн хамтын ажиллагааны боломжуудыг үнэлэх, үүнд Өмнөд Америкийн төслүүдэд боловсруулж гүйцэтгэсэн техникийн, зохион байгуулалтын болон менежментийн шийдлүүдийг хэрэглэж болох эсэхийг шалгах,
- бүрэн хэмжээний ажлын төлөвлөлттийг эзэмшсэн туршлагын үндсэн боловсруулах нөхцлийг бүрдүүлж хамтрагч, санхүүжүүлэгч нартай холбоо тогтоох.

Ажлын хэсгийн айлчлалын үр дүнг үндэслэн эхний үе шатанд дараахи ажлууд хийгдэнэ:

- 1) Монголын ЗГ-т хамтрагч талуудын санаалыг тусгасан гар аргаар олборлох тухай хуулийн төслийг боловсруулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, эсвэл өнөөгийн хуулийн төсөл батлагдвал үүсэх бэрхшээлүүдэд тусламж дэмжлэг үзүүлэх,
- 2) нинжа нарын үйл ажиллагааг анхааралдаа авч ажиллах байгалийн баялгийг зөв зохистой хуваарилан удирдах зохион байгуулалтын бүтцүүдийг бий болгох,
- 3) нинжа нарт бохирдолт багатай, өндөр бүтээмжтэй технологи эзэмшүүлэх зорилгоор ноу-хау (патент) дамжуулах ажлыг эхлэх.
- 4) Төслийн сонгогдсон газрын иргэдийн амьжиргаа ба тухайн газрын байгалийн нөөцийн тогтвортой менежментэд бичил уурхайн олборлолтын байгаль орчин, нийгэм эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ хийгдэнэ.

Төслийн үндсэн 4 чиглэлийн үйл ажиллагаанаас дараахи үр дүнгүүд гарна. Үүнд:

Зорилго 1: Хууль эрх зүй, зохицуулалтын орчинг бий болгосон байна.

Ил тод, шударга зохицуулалт бий болгох нь бичил уурхайн албан бус олборлолтын үйл ажиллагааг хууль ёсны болгох тааламжтай нөхцөл бүрдэнэ.

Шударга хууль эрх зүйн орчин бүрдүүлэх: хууль эрх зүйн үйл явцад санал бодол (харилцан зөвшөөрсөн хууль, дүрэм, журмыг боловсруулах, зөрчлийн менежментийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх)-оо хуваалцаж хуулийн төсөлд тусгуулах, бүх хамтрагч, харилцагч талуудын үйл ажиллагаандаа дагаж мөрдөх удирдамж (эрх зүйн холбоотой үйл ажиллагаа, хяналт мониторинг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа) гаргах хэрэгцээ шаардлага гардаг. Хөдөөгийн иргэдийн амьжиргааны нөхцлийг сайжруулахад сум/аймгийн засаг захиргаа болон бичил уурхай эрхлэгчдэд боломж олгоход Бичил уурхайн үйл ажиллагааг хөдөөгийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулах нь гол асуудал юм.

Үр дүн 1.1: хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх

Монгол улсын засгийн газарт бичил уурхайн олборлолтын тухай хуулийн төслийг боловсруулахад туслана.

Зорилго 2: Бичил уурхайн салбарын хүрээнд бүтэц зохион байгуулалтыг бий болгоход туслэх

Бичил уурхайн салбарт бүтэц зохион байгуулалтыг бий болгож, бүхий түвшинд хамтран ажиллах болно.

Бүс нутгийн байгалийн нөөцийн тогтвортой менежментийн бүтцийг бий болгох: төсөл нь бичил уурхайтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд холбогдох талуудыг оролцуулж үйл ажиллагааг тогтвортой үр дүнтэй явуулдаг болоход хувь нэмэр оруулна. Бүтэц зохион байгуулалт (АМГТХЭГ-ийн дэргэд Бичил уурхайн тасаг/нэгж байгуулж, бичил уурхай эрхлэгчдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг Уул уурхайн аврах албаны тусламж дэмжлэгтэйгээр үзүүлэх)- ыг бэхжүүлэх, салбар хооронд зохицуулалт хийх, удирдлагын төвлөрлийг сааруулах, орон нутгийн засаг захиргааны оролцоог бий болгох нь нэн тэргүүний стратегийн асуудал байна.

Үр дүн 2.1: Хамтын ажиллагааны үндэс

Бичил уурхайн салбарыг хөгжүүлэх, энэ салбарт ажиллаж буй хүмүүсийг ойлгон тэднийг дэмжин туслахад бүхий л түвшинд хамтын ажиллагааг бий болгосон байна.

Үр дүн 2.2: Бүтэц зохион байгуулалт

Бичил уурхайн олборлолттой холбоотой байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтын менежментийг бий болгоход бүтэц зохион байгуулалтыг бий болгосон байна.

Үр дүн 2.3: Хандивлагч/ивээн тэтгэгчдийн зохицуулалт

Уул уурхайн салбарт хэрэгжиж буй төслүүд, хандивлагчдаас үзүүлж буй тусламж дэмжлэгийг бичил уурхайн салбарыг хөгжүүлэхэд чиглүүлэн зохицуулалт хийсэн байна.

Төслийн хэрэгжилтийн эхний шатанд бичил уурхай олборлолтын талаар олон нийтийн санал бодлыг сонсох, холбогдох мэдээллийг бий болгох арга хэмжээнээс эхлэн хамтрагч талуудтай хамтран ажиллана.

Зорилго 3 Чадавхийг бий болгох: Олборлолтын үйл ажиллагааг сайжруулан аюулгүй ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлж бичил уурхай эрхлэгчид ба бусад холбогдох талуудын мэдлэг, үр чадвар, техник технологийг сайжруулах;

Төсөл хэрэгжүүлэхээр сонгож авсан газруудад бичил уурхай эрхлэж буй хүмүүс нь олборлолтын үйл ажиллагаандаа дэвшилтэт технологи нэвтрүүлэн, аюулгүй ажиллагааг ханган, албан ёсоор олборлолт явуулах баталгаа, эрхээр хангагдсан байна.

Бичил уурхайн эрхлэгчдийн дунд нөөцийн тогтвортой ашиглалтыг бий болгон тэдний амьжиргааг сайжруулах:

Холбогдох талуудын дунд хамтран ажиллах таатай уур амьсгалыг бүрдүүлсний дараа төсөл нь нөөцийн зохистой ашиглалт/ менежмент (байгаль орчны хамгаалал, орд газрыг бүрэн гүйцэт ашиглах, олборлогчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хангах, нөхөн сэргээх ажиллагаа)-д гол анхаарлаа хандуулах болно. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь шинэ мэдлэг, технологи нэвтрүүлэх, ур чадварыг сайжруулах үйл ажиллагааг уялдуулан нэгтгэн цаашид харилцагч талууд, бүтэц зохион байгуулалтын чадавхи эрх мэдлийг нэмэгдүүлэхэд чиглэх болно. Эдгээр нь бичил уурхайн үйл ажиллагааг албан ёсны болгоход туслах болно. Бичил уурхай эрхлэгчдийн талаар олон нийтийн санал бодлыг сонсох ажлыг зохион байгуулж мэдээллийг бий болгон үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ бичил уурхай эрхлэгчдэд тулгарч байгаа өнөөгийн асуудлуудыг бичил уурхай эрхлэгчид ба холбогдох байгууллагуудын хамтын оролцоотой шийдэх ажилтай уялдуулах болно.

Үр дүн 3.1: Технологи ба ур чадвар

Одоогийн хэрэглэж буй технологи, бичил уурхай эрхлэгчдийн ур чадварын өнөөгийн байдалд үнэлгээ өгч, шинэ мэдлэг (ноу-хоу) ба үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах, сайжруулсан байна.

Үр дүн 3.2: Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх газрыг сонгох

Төслийн туршилтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх газрыг сонгосны дараа тухайн газрын бичил уурхай эрхлэгчдэд олборлолт ба аюулгүй ажиллагааны дэвшилтэд технологи, арга техникээс суралцаж хэрэглэхэд туслах болно.

Зорилго 4: байгалийн нөөцийн менежмент ба хөдөөгийн хөгжлийн талаар цогц мэдлэгийн суурийг бий болгох

Байгаль орчин, нийгэм, эдийн засаг, амьжиргааны индикатор/үзүүлэлтийг тогтоож, байгалийн нөөцийн ашиглалтанд үнэлгээ өгч, зарим шаардлагатай арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтыг амьжиргааны баталгаа болгох: төсөл нь үйл ажиллагаагаа чиглүүлж буй газруудын байгаль орчны өнөөгийн байдал, тулгарч буй асуудлуудад үнэлгээ өгөх, байгалийн нөөцийн менежментийг амьжиргааны олон асуудлын стратеги, хувилбар, хязгаарлалтыг авч үзсэн нийгэм эдийн засгийн урт хугацааны хөгжлийн стратегитэй уялдуулах тусгай зөвлөмж гаргахад чиглэх болно. Энэ үнэлгээ нь төслийн үйл ажиллагаа чиглэж буй газрын байгаль орчны нөхцөл байдалтай холбоотой бенчмаркийн тоо баримтыг гаргаж өгч, бичил уурхайн үйл ажиллагаа, мал маллагаа болон бусад эдийн засгийн үйл ажиллагааны хооронд харьцуулалт гаргах болно.

Үр дүн 4.1: Үнэлгээ ба мониторинг

Сонгосон газруудын нийгэм эдийн засаг, байгаль орчны байдалд үнэлгээ хийж, хяналт мониторинг явуулсан байна.

Үр дүн 4.2: байгалийн нөөцийн тогтвортой менежментийн хувилбар гаргах

Байгаль орчны гол түлхүүр ба хүндрэлтэй асуудлуудын талаарх ойлголтыг бий болгосон байна.

Үр дүн 4.3: бүтэц зохион байгуулалтыг бий болгох

Бичил уурхайн үйл ажиллагааг хөдөөгийн хөгжил, байгалийн нөөцийн асуудалтай үр ашигтай уялдуулах бүтэц зохион байгуулалтын талаар зөв ойлголтыг бий болгосон байна.

Төслийн эхний шат ба туршилтын хугацаанд төслийн үйл ажиллагаанд оролцогч талууд (бичил уурхайн эрхлэгчдийг оролцуулан)-ын хооронд итгэлцэл ойлголцлын үндсийг бий болгоод зогсохгүй бас бичил уурхайн салбарыг хөдөөгийн тогтвортой хөгжил, бэлчээрийн асуудал, ядуурлыг бууруулах зэрэг бусад холбогдох салбарын асуудлуудтай уялдуулах холбоотой болгох ойлголтыг бий болгоно.

Төслийн үйл ажиллагааны эхний шатанд 2006 оны эхэнд үнэлгээ хийлгэж, төслийн дараагийн шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт хийх удирдамжийг гаргах болно.

Төслийн эхний шатны үйл ажиллагаанаас эхлэн Швейцари болон Монгол улсын холбогдох талууд хамтран ажиллана. Үүний тулд Швейцарийн багийг Монголын бүтэц зохион байгуулалтанд нийцэж ажиллуулах арга хэмжээг авна. Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх загвар/тойм нь төслийн эхний шатны үйл ажиллагааны зохион байгуулалтыг удирдан чиглүүлнэ (АМГТХЭГ нь гол хэрэгжүүлэгч байгууллага байх, Уул уурхайн аврах алба, сум орон нутгийн засаг захиргаа нь төслийн хэрэгжилтэнд үндсэн хамтрагч талууд байна).

6.8.2. Дараах үе шатанд гүйцэтгэгдэх бүрэн хэмжээний ажлуудыг багтаах төслийн бүтцүүд

Эхний үе шат дууссаны дараа төсөл хэрэгжүүлэлт нь дараах асуудлуудад анхаарч ажиллах шаардлагатай:

- **Орон нутагт байгалийн баялгийг зөв зохистой хуваарилах бүтцийг бүрдүүлэх** төсөл нь бичил уурхайтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд холбогдох талуудыг оролцуулж үйл ажиллагааг тогтвортой үр дүнтэй явуулдаг болоход хувь нэмэр оруулна. **Салбар хооронд зохицуулалт хийх, удирдлагын төвлөрлийг сааруулах, орон нутгийн засаг захиргааны оролцоо-г** бий болгох нь нэн тэргүүний стратегийн асуудал байна. Хууль эрх зүйн процесс нь байнга шинэчлэгдэж боловсронгуй болж байдаг (хуульд нэмэлт өөрчлөлт, зохицуулалт хийж байдаг) бөгөөд хамтрагч нарын санал бодлыг тусгаж байдаг. **Нинжа нарын үйл ажиллагаа нь орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд** багтаж байгаа явдал нь нинжа болон сумын засаг захиргаа нарт **амьдралын нөхцлөө сайжруулах** боломжтой гэдгийг харуулж буй үндсэн санаа юм.

- **Бичил уурхай эрхлэгчдэд хэрэглэдэг тоног төхөөрөмжийг сайжруулж, ингэснээр амьдралын нөхцлийг нь дээшлүүлэх.** Төслийн эхний үе шатны явцад холбогдох хамтрагчуудын хооронд харилцан ойлголцлын уур амьсгалыг бүрдүүлсний дараа нөөц баялгад чиглэгдсэн асуудлуудад анхаарлаа төвлөрүүлэх шаардлагатай (**байгаль орчны хамгаалал, ашигт малтмалыг иж бүрэн ашиглах, хөдөлмөр хамгаалал ба аюулгүй ажиллагаа, нөхөн сэргээлт**). Ажлын гүйцэтгэлийн явцад технологи дамжуулах болон сургалт явуулах үйлдлүүд хийгдэх бөгөөд үүний үр дүнд **төсөлд оролцогч талууд, зохион байгуулалтын бүтцүүд улам туршлагатай, боловсронгуй болох юм. Тэд нинжа нарыг хууль эрх зүйн орчинд шилжин нийгмийн баталгаат орчинд амьдрахад нь туслах юм.**
- **Зөв ойлголт бий болгон баталгаажуулах.** Бичил уурхай эрхлэгчдийг өмгөөлөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах кампанит ажлыг зохион байгуулснаар хүн бүрт, холбогдох бүх байгууллагуудад нинжа нарын талаар зөв ойлголт өгөх зорилготой юм.

Төслийн хэрэгжилтийн үндсэн шатны үйл ажиллагааны талаар төслийн эхний шатанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа ба үйл ажиллагааны хэрэгжилтийн дунд үеийн үнэлгээний үр дүнгээс тодорхойлох болно.

6.9. Төслийн үйл ажиллагаа чиглэж буй хүмүүс ба төслөөс ашиг хүртэгчид

Төслийн үйл ажиллагаанд оролцон төслөөс ашиг хүртэгчид нь бичил уурхай эрхлэгчид ба тэдгээрийн гэр бүлийн хүмүүс, сум орон нутгийн засаг захиргааны холбогдох ажилтнууд, сумын байгаль орчны байцаагчид болон улсын хэмжээнд ашигт малтмалын асуудал харицдаг байгууллага (АМГТХЭГ)-ын холбогдох ажилтнууд байна.

- **Бичил уурхай эрхлэгчид** нь тэдний эрхэлж буй үйл ажиллагааг албан ёсны болгох замаар төслөөс шууд ашиг хүртэгчид байна. Бичил уурхай эрхлэгчид элдэв дарамт шахалт, айдасаас ангид байж албан ёсоор хуулийн дагуу олборлолтоо явуулдаг болж, сургууль, эрүүл мэндийн үйлчилгээг авдаг болно. Бичил уурхай эрхлэгчид нь олборлолтын явцад аюулгүй байдлыг хангаж ажиллах ба дэвшилтэд техник технологийг хэрэглснээр **тэдний гэр бүлийхэн** илүү ашиг хүртэх боломжтой болно.
- **Сум орон нутгийн холбогдох ажилтнууд** –ын хувьд сум орон нутгийн хэмжээнд гарч буй зөрчил маргааныг зөвшилцлийн замаар шийддэг чадвартай болно. Эдгээр хүмүүс нь бичил уурхайн үйл ажиллагааг хөдөөгийн хөгжлийн асуудлуудтай уялдуулах, бичил уурхай эрхлэгчдийн хувьд гол харилцагч хамтрагч байх болно.
- **Байгаль орчны байцаагчид** нь бичил уурхай эрхлэгчдийн олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчны асуудлаар ямар арга хэмжээ авч байгаад хяналт тавьж тэдэнд туслах илүү сайн үр дүнтэй арга барилыг олж авна.

- Уул уурхайн салбарын удирдлага захиргааны ажилтнууд бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хамтран ажиллаж, ажлын байран дахь сургалтуудаас суралцах болно.

Түүнчлэн албан ёсны уул уурхайн компаниуд бичил уурхайн эрхлэгчдийн хооронд үүсдэг зөрчил багассан байна.

7. Төслийг хэрэгжүүлэх стратеги ба үйл ажиллагааны уялдаа холбоо, зохицуулалт ба хамтын ажиллагаа

7.1. Хэрэгжүүлэх стратеги

Төсөл хэрэгжүүлэх стратеги нь дараахи гол элементүүдээс бүрдэнэ. Үүнд:

- o Монгол оронд бичил уурхайг хөгжүүлэх хэрэгцээ, асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээ авах (тоног төхөөрөмж, олборлолтын аргууд, сургалтууд, техникийн тусламж дэмжлэг) **ЭНЭ НЬ ИДЭВХИ ХҮЧ ШААРДСАН ҮЙЛ АЖИЛ БАЙНА.**
- o Бичил уурхайн тухай хуулийн төсөл боловсруулахад оролцох: **ЭНЭ НЬ БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ АЛБАН ЁСООР ЯВУУЛАХ БОЛОЛЦОО ОЛГОНО.**
- o Оролцогч талуудын хооронд үүсэх зөрчлийг зохицуулах механизм, зөвшилцлийг бий болгох: **ЭНЭ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТЭДНИЙ ОРОЛЦООГ БИЙ БОЛГОЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦААШИД ТОГТВОРТОЙ ЯВУУЛАХ БОЛОМЖ БҮРДҮҮЛНЭ.**
- o Дэлхийн улс орнууд ялангуяа өмнөд Америкийн орнуудад хэрэгжиж байгаа ижил төсөөтэй төслүүд (ба бусад орнуудын бичил уурхай эрхлэгчид)-тэй холбоо тогтоон харилцан туршлагаа солилцох,
- o Төсөл хэрэгжих эхлэх үеэс эхлэн Швейцари Монгол улсын харилцагч талуудын хооронд хамтын ажиллагаа, оролцоо байх болно. Үүний тулд Швейцари улсаас ажлын хэсэг/баг Монголд ирж ажил хэргийн холбоо харилцааг **ТОГТООСОН.**
- o Төслийн үйл ажиллагааг үндэсний (гадаадын хүмүүсийн оролцоог голлохгүйгээр) оролцоонд үндэслэн хэрэгжүүлнэ.
- o Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд орон нутаг (сум, аймаг)-ийн засаг захиргааны дэмжлэг тусалцааг авах болно.

7.2. Төслийн зохион байгуулалт

Төслийн зохион байгуулалт нь 4 өөр төрлийн түвшнээс бүрдэнэ: улс төрийн (төслийн гэрээг хоёр улсын ЗГ батлана), бодлогын түвшин (Төслийг зохицуулах хороо ба зөвлөлийн комисс), зохион байгуулалтын болон гүйцэтгэлийн түвшин ба үйлдвэрлэлийн түвшин. Уг түвшнүүдийг схемчлэн доор харуулав (5.2).

7.3. Төслийн гол хамтрагч, харилцагч талууд ба тэдгээрийн боломж, чадавхийг үнэлэх

Дараахи хүснэгтэд бичил уурхайн салбарын үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах гол талуудыг сайн ололттой ба муу сул талууд, тэдний төслийн үйл ажиллагаанд оролцох боломжийн талаар товч мэдээлэл өгсөн байна.

Нэрс	Үйл ажиллагааны гол чиглэл	Сайн ба ололттой тал	Муу ба сул тал	Тайлбар:
Үйлдвэр худалдааны яам (ҮХЯ)	Худалдаа, үйлдвэр ийн талаар бодлого гаргаж тэдгээрийн хэрэгжилтийг хангах асуудлыг эрхэлдэг.	Бичил уурхайн асуудлыг зохицуулах нь зүйтэй гэж үзэж хуулийн төслийг шинэчлэн боловсруулсан	Уул уурхайн мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй, бичил уурхайн асуудал хариуцсан ажилтны чадвар сул. АМГТХЭГ-тай ажлын уялдаа муу.	Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах туршилтын ажлуудыг хийх тухай сайдын тушаал гарсан
Байгаль орчны яам	Байгаль орчны талаар баримтлах бодлогыг боловсруулж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авдаг.	Эрдэс баялагийн бус байгалийн нөөцийн ашиглалтанд зөвшөөрөл лизенци олгох үүрэг хүлээдэг.	Ерөнхийдөө бол уул уурхайн салбарын үйл ажиллагааны эсрэг байр суурьтай. Мөнгөн ус (хатуу хяналтын ч дор) хэрэглэхийг зөвшөөрдөггүй. Лизенци, зөвшөөрлийн асуудлаар ямагт сөрөг байр суурийг баримталдаг.	Бичил уурхайгаас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ боловсруулах, мөнгөн усны нөлөөлийг бууруулах талаар төсөлтэй хамтран ажиллаж байгаа.
Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам	Хөдөлмөр цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, ажлын хөдөлмөр зохицуулалтын бодлого	Бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөр, ажлын байрыг албан ёсны болгосноор олон тооны ажлын байр нэмэгдэж хөдөөгийн ядуурал буурна. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн талаар баримтлах бодлогыг боловсруулж батлуулсан.	Бичил уурхай нь нийгмийн олон тооны сөрөг үр дагавар дагуулдаг, зохион байгуулалтанд оруулахад асар төвөгтэй гэж үздэг	Төсөлтэй хамтран ажиллах сонирхол их байгаа. Сайд нь болон эрхэлсэн ажилтан нь манай төслийн талаар сайн ойлголттой
Ашигт малтмал, газрын тосны хэрэг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг. ГАЗрын тос, Геологийн	Бичил уурхайтай холбоотой асуудлаар	Уул уурхайн салбарын дадлага туршлагатай ажилтан	АМГТХЭГ нь Бичил уурхайн х нэгжийг байгуулсан . Энэ

эрхлэх газар	судалгаа, мэдээллийн сан, уул уурхайн үйлдвэрлэл, ашигт малтмалын кадастрын бодлогын хэрэгжилтийг зохицуулдаг.	ажиллах хүсэл эрмэлзэлтэй, үйл ажиллагаагаа сайн зохион байгуулдаг.	дутагдалтай.	нэгжийн ажилтнууд төслийн багийн бүрэлдэхүүнд ажилладаг
Уул уурхайн аврах алба	Түлш эрчим хүчний яамны харьяа байгууллага, төв нь Налайх дүүрэгт байдаг бөгөөд 4 салбарын 50 орчим мэргэжилтнүүдтэй	ХХАА-ны асуудал эрхэлдэг мэргэжлийн ганц байгууллага. Боловсон хүчин, аж ахуйн бааз суурь сайн.	Үйл ажиллагаа нь улсын төсвөөс санхүүждэг тул хязгаарлагдмал үйл ажиллагаа явуулдаг.	Төсөлтэй хамтран хөдөлгөөнт аврах хэсэг болон, сургалт-мэдээллийн төв байгуулан ажиллаж байгаа.
Улсын мэргэжлийн хяналтын газар	Ерөнхий сайдын дэргэд ажилладаг	BGR-гийн уул уурхайн аюулгүй ба эрүүл мэнд төслийн гол хамтрагч	Албан бус салбартай ажиллах эрх олгогдоогүй.	Хамтран ажиллах үндэс суурь тавигдаж байгаа.
Байгаль орчны байцаагчид	Улсын мэргэжлийн хяналтын газрын харьяанд ажилладаг.	Бүх сумдын байгаль орчны байцаагчид, одоогоор бичил уурхай эрхлэгчд (тэдний тоо, олборлолт явуулж буй газар гм) ийн талаар хамгийн сайн мэдлэгтэй, зарим сумдын хувьд бичил уурхай эрхлэгчдэд хандах хандлага сайн ойлгомжтой байдаг.	Байцаагчид нь уул уурхайтай холбоотой техникийн мэдлэг, чадвараар дутмаг байдаг. Ажил үүргийн хуваарь нь зөрчилтэй.	Сум орон нутагт хамтран ажиллах гол хүн болдог
Ажил олгогч эздийн холбоо	ТББ, ажил олгогч эздийн шүхэр байгууллага, төрийн ба хувийн үйлдвэрүүдийн 8000 гишүүдтэй.	ОУХБ/АЙПЕК-ийн төслийн гол хамтрагч байгууллага, бичил уурхай эрхлэгчдийн асуудал, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар идэвхитэй	Хөрөнгийн эх үүсвэр дутагдалтай.	Хамтран ажиллах бүрэн бололцоотой. Баянхонгор аймагт төслийн ажлаа явуулж эхэлсэн

		ажиллаж байгаа.		
Монголын уул уурхайн ассиаци	ТББ, албан ёсны уул уурхайн үйлдвэрүүдийн шүхэр байгууллага, 130 уул уурхайн компаниудын 60 орчим гишүүдтэй.	Бичил уурхайн талаар анхны бага хурлаа 2002 онд хийсэн, ОУХБ/ АОЭХ-ны хүүхдийн хөдөлмөрийн төсөлтэй хамтран ажиллаж байна.	Бичил уурхайн салбарын асуудлаар дагнан ажилладаггүй.	Монголын уул уурхайн салбарын бодлогын талаар ҮХЯ-аас илүү анхаардаг. Орчин үеийн дэвшилтэт сэтгэлгээтэй.
Аймгийн засаг захиргаа	Төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх үүрэгтэй	Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулахад хамтран ажиллах гол субъект	Бие даасан үйл ажиллагаа дутмаг. Аймгуудын засаг захиргааны ажилтнуудын чадвар сул.	Зарим аймгийн удирдлага бичил уурхайн асуудлаар хамтран ажиллаж байгаа
Сумын засаг захиргаа	Улсын хэмжээнд 300 сумд байдаг.	Зарим сумд нь бичил уурхайн тухайлбал нийгмийн ба хууль дүрэмтэй холбоотой зөрчлийг бууруулах талаар ажиллаж дэмжлэг туслалцаа үзүүлэхэд бэлэн байдаг. Зарим сумд нь орон нутгийн зүгээс зөвшөөрөл авах хэрэгтэй албан ёсны уул уурхайн үйл ажиллагааны хууль эрх зүйн зохицуулалтанд идэвхитэй оролцдог.	Бичил уурхайн асуудлаар туршлага сул, Зарим сумдууд бичил уурхайн асуудлаар сөрөг ойлголттой байдаг.	Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулахад хамгийн үүрэг рольтой оролцох субъект
Албан ёсны уул уурхайн компаниуд	130 орчим уул уурхайн компаниуд байна.	Зарим ялангуяа саяхан бий болсон уурхайнууд нь зарим технологийн ба байгаль орчны стандартыг гаднаас оруулж ирж байна.	Бичил уурхай эрхлэгчидтэй ихэнхидээ зөрчилд орж байдаг ялангуяа шороон ордын хувьд, зарим компаниуд нь хуучин үр ашиггүй технологитой	Хамтран ажиллах хандлага бий болж байгаа.

			байдаг нь байгаль орчинд учруулах хор нөлөө ихтэй байна.	
Уул уурхайн жижиг тоног төхөөрөмж үйлдвэрлэгч хувийн компаниуд	Ашигт малтмалыг баяжуулах технологийн тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг	Ашигт малтмалын технологийн хаягдал, мөнгөн усны хор холбогдлыг бууруулах тоног төхөөрөмжүүд үйлдвэрлэн туршдаг	Тоног төхөөрөмжийн үнэ нь бага биш учир бичил уурхай эрхлэгчид худалдан авахад хүндрэлтэй	Тоног төхөөрөмжжүдийн ажлын үзүүлэлт нь гадныхаас дутуугүй бөгөөд үнэ нь бага тул болоцоотой.
Монгол улсын үндэсний их сургууль	Судалгаа шинжилгээний байгууллага, Хөгжил ба судалгааны төв (Дк. Ёорг янзан)	Монгол улсын ялангуяа мал маллагаа ба нүүдлийн ахуй амьдрлын талаар нэлээд их судалгаа явуулсан, нэлээд туршлагатай.	Хээрийн судалгааны ажил хийхэд санхүүжилт хязгаарлагдмал Бичил уурхайн салбарын тухайд туршлага бага.	МУИС-ийн хувьд судалгаа шинжилгээний ажил явуулж, бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.
ШУТИС-ийн УУИС	Уул уурхайн бүх мэргэжлийн инженерүүдийг бэлтгэдэг нэр хүндтэй сургууль	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дадлага туршлагатай эр-дэмтэн багш нартай хамтран ажиллах болоцоотой	Хөрөнгийн эх үүсвэр дутмаг.	Бичил уурхайн тухай хууль боловсруулахад оролцсон. Энэ чиглэлээр ажиллах сонирхолтой
ТББ	Орон нутгийн зарим хөдөлгөөн - үүд байгалийн нөөцийн ашиглалтанд нутгийн иргэдийн эрх ашгийг тусгахад тусламж дэмжлэг үзүүлдэг.	Орон нутгийн хөдөлгөөнүүд нь олон нийтийн дэмжлэгийг хүлээж төр засгийн газраас тодорхой асуудлаар хариулт авч чадаж байна.	Чадавхи ба сулжээний асуудал маш сул ба одоогоор бичил уурхайн талаар мэдээлэл сурталчилгаа бараг байхгүй байна.	
Бичил уурхай эрхлэгчид	Бичил уурхай эрхлэгчдийн тоо 80,000- 100,000-ын хооронд байна (Монгол орны бараг бүх газруудад)	Сайн бөгөөд өртөг зардал багатай геологичид. Нэлээд уян хатан, нүүдлийн байдалтай, алт бүхий газруудыг албан ёсоор ашиглахад бэлэн байдаг, татвар	Зохион байгуулалт огт байхгүй (холбоод, лобби групп, шүхэр байгуулагууд), орон нутгийн малчид ба бусад хүмүүстэй малын бэлчээрийн асуудлаар зөрчилд ордог.	Хэрэгжүүлэх төслийн зорилтот бүлэг

		төлдөггүй, хөдөөгийн эдийн засгийн мөнгөний эргэлтийг би болгож өгдөг,	Олборлолтыг албан ёсны зөвшөөрөлгүй явуулдаг, уламжлалт арга туршлага дутмаг байгаль орчинд учруулсан хор хохирлын нэлээд хэсгийг оногдуулдаг, заримдаа хөдөө орон нутагт байдаг үйлчилгээ (харъяа бүртгэл, эрүүл мэнд аюулгүй ажиллагаа гм)г авч чаддаггүй.	
Олборлолт эрхэлдэггүй орон нутгийн хүмүүс			Бичил уурхайтай холбоотой олон асуудлууд өөрчлөлт (гол усны ширгэлт, усны бохирдол тоос гм) байдаг гэж зарим хэсэг нь үздэг.	
Малчид	Хөдөө орон нутагт бараг 1 сая малчид байдаг.	Мал маллагаа нь хөдөө орон нутгийн байгаль орчны асуудлуудтай нэлээд уялдсан (жишээ нь аргалыг дулааны эх үүсвэр бий болгоход ашигладаг нь орон нутгийн ургамалжилтыг хамгаалахад тустай)	Хөдөөгийн ядуурал, малын бэлчээрийн талхагдал нь малчдыг бичил уурхай эрхлэх (ямар ч туршлагагүйгээр)д хүргэж байна, малчдын ихэнхи нь ган зуданд малаа олноор алдснаар амьжиргааны эх үсвэргүй болж, бичил уурхай эрхлэхэд хүргэсэн	
Бусад ивээн тэтгэгчид/донорууд	Олон донор байгууллагууд Монгол улсад идэвхитэй ажиллаж тусламж дэмжлэгээ үзүүлж байна.	Зарим байгууллага (Канад, Норвеги, ЖАЙКА, Дэлхийн банк) нь бичил уурхайн салбарын талаар илүү ойлголт бий болгох үүднээс	Одоогоор бичил уурхайн өөр бусад төслүүдийг ивээн тэтгэж хэрэгжүүлээгүй байна.	Бичил уурхайн үйл ажиллагаа ба хөдөөгийн хөгжилтэй бичил уурхайн үйл ажиллагааг уялдуулахад бусад донор байгууллагуудыг зохицуулахад хувь нэмэр оруулна.


		судалгаа явуулж байна.		
--	--	---------------------------	--	--

7.4. Төслийн хамтрагчид болон оролцогчид

Төслийг хэрэгжүүлэх үе шатанд хамтрагчдын тоо нэмэгдэх болно. Ерөнхийдөө төслийн хамтрагч болон оролцогч гэдэг ухагдахуунд үндэсний хэмжээний байгууллагуудаас эхлээд хувийн бага оврын үйлдвэрлэл явуулдаг, бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаатай хамааралтай буюу холбоотой бүх этгээд багтана. Тэдгээр нь:

Хамтрагч	Гүйцэтгэх үүрэг
Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар	Шууд хамтрагч, төслийн гүйцэтгэлийн менежментэд хамтран оролцох
Уулын аврах анги	Бичил уурхай эрхлэгчдэд сургалт явуулж, зөвлөгөө өгөх
Монгол дахь Konrad Adenauer-ийн сан	Бичил уурхай эрхлэгчид болон уурхайчдын холбоодуудад суурь байгууллага/ассоциаци байгуулахад нь дэмжлэг үзүүлэх
Монголын үндэсний их сургууль	Сонгосон бүс нутгуудад явуулах төслийн үндсэн судалгааны ажлуудыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх
Орон нутгийн засаг захиргаа (сум, аймгийн)	Аймаг, сумын удирдлагын хэмжээнд дэмжлэг тусалцааны арга хэмжээг гүйцэтгэх үндсэн хамтрагчид
Бичил уурхай эрхлэгчид болон тэдгээрийн холбоод	Төслийн үр дүнг хүлээн авагчид
Хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн үйлдвэрүүд, тэдгээрийн холбоод	Бичил уурхай эрхлэгчидтэй холбоотой үүсэх зөрчлүүдийг зарим нэг буулт хийх замаар зохицуулах ажилд хамтран ажиллах
Зөвшөөрөл бүхий алт худалдан авах төлөөлөгч, банкууд	Бичил уурхай эрхлэгчдийн дунд орлуулж байгаа алтны зах зээлийн механизмыг хуульчлах асуудалд оролцох
Орон нутгийн эмч, сургуулийн багш нар, байгаль орчны байцаагч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны байцаагч нар	Бичил уурхай эрхлэгчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд сургалт явуулах
Орон нутгийн үйлчилгээний байгууллагууд	
Үндэсний төмрийн механикийн үйлдвэрүүд	Нинжа нарт зориулж сайжруулсан болон шинэ багаж, тоног төхөөрөмж үйлдвэрлэхэд хамтран ажиллах
Бусад уул уурхайн болон ШХХАА-ийн төслүүд	Үндэсний нөөц баялгийн менежментийн бодлого боловсруулахад тусалцаа үзүүлэх

7.5. Төслийг гүйцэтгэх дэвшүүлж буй схем



Төслийн үйл ажиллагаанд хяналт тавьж, стратегийг тодорхойлоход 1)төслийн удирдах зөвлөлийг байгуулна. Энэ зөвлөлд төслийг хэрэгжүүлэх гэрээнд

гарын үсэг зурсан талууд болон бусад холбогдох талуудын төлөөлөл орж, жилд 2 удаа хуралдаж төслийн хэрэгжилтэнд хяналт тавьж, төслийн төлөвлөлтийг баталж, төслийн стратегийг тодорхойлж, бодлогын асуудалд дэмжлэг тусалцаа үзүүлнэ (Зураг 1).

Захирлуудын зөвлөлөөр баталсны дагуу ШХХАА тай гэрээ байгуулан төслийг Проект консалт хэрэгжүүлнэ. Проект консалт нь төслийн Захирал (Дк. Майкл Приистер)г томилох ба төслийг удирдан явуулах төслийн багийг бүрдүүлнэ. Цаашид энд АМГТХЭГ- аас төслийн Зөвлөх (Дк. Ч. Энхзаяа)”ийг оруулна.

Төслийн Захирал нь төсөл хэрэгжүүлэх багийг төслийн Менежер, Техникийн эксперт, Санхүү, захиргааны ажилтан, Орчуулагч гэсэн бүрэлдхүүнтэй бий болгоно. АМГТХЭГ нь Техникийн эксперт (уул уурхайн 3), Геологи, кадастрийн албаны мэргэжилтэн (2)-ийг томилон ажиллуулах нь Бичил уурхайн тасгийг байгуулахад оролцох болно.

Энэ нь төслийн стратегийг тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, төсөв хуваарилах, шаардлагатай зүйл, үйлчилгээг худалдан авах төлөвлөгөө боловсруулахад чиглэх болно. Төслийн захиралууд, төсөл хэрэгжүүлэгч баг нь үйл ажиллагаагаа уялдуулж, үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулж хэрэгжүүлнэ. Мониторинг явуулж, өөрөө өөрсдөө үнэлгээ өгдөг байна. АМГТХЭГ ба Проект консалт ба төслийг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурсан талуудын хооронд маргаан гарсан тохиолдолд дипломат зарчмаар шийдвэрлэнэ.

Төслийн багийн бүх гишүүд ба бусад гол харилцагч **хамтрагч талуудынхүлээх үүрэг хариуцлагыг** Хавсралт 9-т дэлгэрэнгүй байдлаар өгсөн болно.

7.6. Нөөц бололцоо

7.6.1. ШХХАА-аас оруулах хувь нэмэр

ШХХАА-ийн зүгээс төслийн эхний шатыг хэрэгжүүлэхэд хүний болон санхүүгийн нөөц бололцоог хангах боломжтой (төслийн талаар Хавсралтаас харах):

- орон нутгийн зөвлөх баг (төслийн менежер, уурхайн шинжээч, орчуулагч, нягтлан бодогч),
- Үндэсний Зөвлөх (6 сараар)
- Олон улсын менежмент ба техникийн эксперт (нийт 11 сар, Проект консалт: менежмент - 3.5 сар, хууль эрх зүйн асуудал – 2.0 сар, туршилтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт – 1.5 сар, сонгосон газарт хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа – 1.0 сар, танилцах аялал – 1.0 сар, бүтэц зохион байгуулалтыг бий болгох – 1.0 сар, сургалтын материал боловсруулах – 0.5 сар), 0.5 сар – одоогоор тодорхой зүйл төлөвлөөгүй байна.
- Үндэсний богино хугацааны мэргэжилтэн (28 сараар)
- төслийн үйл ажиллагааны санхүүжилт

- Туршилтын төсөл Уул уурхайн аврах албаны үйлчилгээ, тусламж, сургалт семинар, сургалтын материал, сургалт, судалгаа Латин америкийн орнуудад хэрэгжүүлж буй төслүүд ба бичил уурхай эрхлэгчдтэй уулзах танилцах аялалыг хийж бичил уурхай эрхлэгчдэд дэмжлэг туслалцаа хүргэх,

ШХХАА-аас оруулах хувь нэмэр

		(Швейцари франкаар)
Хүний нөөц	114,5 эксперт/сараар	
Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны зардал (дотоодод)	170.300
Бусад санхүүжилт	Материалын ба 3-дагч талуудын зардал	478.750
Төслийн эхний шат (2005-6 сар – 12 сар)-ны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах нийт санхүүжилт		1.133.950

7.6.2 Монгол улсын ба АМГТХЭГ-ын зүгээс оруулах хувь нэмэр

- АМГТХЭГ дээр Бичил уурхайн тасгийг саяхан байгуулсан бөгөөд энэ тасаг нь цаашид бичил уурхайн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх болно. Үйл ажиллагааг эхлүүлээд байна.
- Төсөл хэрэгжүүлэх багийг ажлын байраар хангах,
- Бичил уурхайн тасгийн үйл ажиллагааны зардлыг хариуцах,
- Мэдээлэл
- Тухайн салбар дотор үйл ажиллагааны зохицуулалт хийж, уялдуулах.

АМГТХЭГ-ын оруулах хувь нэмэр

Хүний нөөц	72.0 эксперт/сараар	(Швейцари франкаар)
Үйл ажиллагааны зардал		39.100
Бусад санхүүжилт		10.000
Төслийн эхний шат (2005-6 сар – 12 сар)-ны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах нийт		49.100

санхүүжилт		
------------	--	--

8. Эрсдэл, боломж, нөхцлүүд

Гарч болох эрсдлийн тухайд “эрсдлийг бууруулах стратеги”-ийг гол болгон баримтлах болно.

Эрсдлүүд	Эрсдлийг бууруулах стратеги
Олон улсын ба албан ёсны уул уурхайн үйдвэрлэл, тэдгээрийн үйл ажиллагааны лобби/нөлөө, шахалтаас болж бичил уурхайн тухайн хуулийг гаргах ажил удааширч болох	Зөвшилцлийг бий болгох, үйл ажиллагааг бичил уурхай эрхлэгчид, орон нутгийн засаг захиргаа болон тус салбарын зохион байгуулалт гэсэн 3 чиглэлээр явуулах, зөвшилцлийг бий болгох
Бичил уурхай эрхлэгчид өөрсдөө хуулиар албан ёсны болох сонирхолгүй гэдгийг мэдсний дараа төр засгийн газар бичил уурхайн үйл ажиллагааг албан ёсны болгох үйл ажиллагааг сулруулж болох	Бичил уурхай эрхлэгчидтэй ажиллах арга барилаа өөрчлөх, тэдэнд чиглэсэн үйл ажиллагаа явуулах
Лизенци олголтыг албан ёсны уурхайнуудад илүү олгодог байдал, авилгал, сум орон нутагт холбогдох мэдээлэл хожуу хүрдэг зэргээс болж хууль эрх зүйн орчинд өөрчлөлт гарсан ч бичил уурхай эрхлэх сонирхол бүхий газруудыг олгоход ахиц гарахгүй байж болох	Албан ёсны компаниуд, сум орон нутгийн засаг захиргаа, бичил уурхай эрхлэгчидтэй бичил уурхайн бүсийг тогтоох талаар харилцан ярилцаж хэлэлцэх, газрыг хуваарилах талаар холбогдох улс төрийн хүчинтэй ярилцахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, шийдвэр гаргахад ил тод байдлыг дэмжих, сумдыг лизенцитэй холбоотой шинэ мэдээллийг цаг тухайд нь авдаг байх, албан бус бичил уурхай эрхлэгчдэд сургалт, чадавхийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах
Бичил уурхай эрхлэгчид шинэ арга, техниктэй болоход төдийлөн санаачлагатай бус байж болох	Энд гарах эрсдэл баг, технологийн өөрчлөлт хийхэд саад болох уламжлал байхгүй.
Хууль эрх зүйн хувьд саад, зардал өндөр байгаа нь олон нийтийг хууль эрх зүйн талаар өөрчлөлт гаргахыг шаардсан үйл ажиллагаанд нийтээр нь татан оруулах	Үүний гол хариулт бол зөрчлийг зохицуулах, шийдвэрлэх арга замыг олох, орон нутгийн зохицуулагчид гол оролцогч талууд (албан ёсны лизенци эзэмшигчид, сумдын засаг захиргаа, бичил уурхай эрхлэгчид)-ын хооронд зөрчлийг зохицуулах талаар

	мэдлэг, аргачлалд суралцсан байх,
Байгаль орчны асуудалд бичил уурхай эрхлэгчид (орон нутгийн засаг захиргаа) зардал өндөртэй учраас арга хэмжээ авахгүй байх,	Технологийн багц саналууд байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулахад туслана.
Бичил уурхай эрхлэгчид нөхөрлөл, хоршоолол, хэсгүүдэд хуваагдан ажиллахад татгалзаж болох	Эрсдлийг бууруулахад төсөл бичил уурхай эрхлэгчдийн дунд “гал” болдог уламжлалыг ашиглах талаар судалгаа явуулж зохион байгуулалтанд оруулах арга хэмжээ авна.
Бичил уурхай эрхлэгчид нь нүүдлийн байдлаар ажиллах	Хамтын ажиллагааг урт хугацаанд явуулж, машин тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийх ажлыг шаардсан дэд төслүүд байх хэрэгтэй болох, үүний тулд шилжилт хөдөлгөөн ихтэй шороон ордод ажиллаж байгаа бичил уурхай эрхлэгчдийн дунд орон нутагт богино хугацаанд хийдэг тоног төхөөрөмж ашигладаг болгох, харин үндсэн ордын хувьд хууль эрх зүйн зөрчилгүй орчинг бий болгосны дараа харьцангуй урт хугацааны хамтын ажиллагаанд чиглэсэн арга хэмжээг авна.

ШХХАА ийм төслийг хэрэгжүүлэхэд:

- өөрийн дэмжлэг тусламжаа байгаль орчин ба бусад (хүний нөөц, материал, санхүүгийн) асуудалд тодорхой урт хугацаанд хүргэхэд чиглэх
- ШХХАА нь Монгол улсын төр засгийн газар ба бусад хандивлагчдын хэрэгжүүлж буй хөтөлбөр төслүүдтэй сайн харилцаа тогтоох
- ШХХАА нь өмнөд америкийг Эквадор, Перу, Боливи улсуудад бичил уурхай эрхлэгчдэд дэмжлэг туслалцаа үзүүлж ирсэн 12 жилийн туршлагаас хуваалцах
- ШХХАА нь бичил уурхайн стратегийг боловсруулах асуудлаар бусад орнуудын гол түншүүдтэй харилцаа холбоо тогтоон ажиллах

Төсөл хэрэгжүүлж байгаа өнөөгийн нөхцөл байдалд:

- бичил уурхай эрхлэлтийн албан бус байдлыг өөрчлөх улс төрийн нөхцөл байдал бий болж байна.

- Төр засгийн газар ба бусад бүс нутгийн хөгжлийн асуудлаар гол хамтрагч талууд хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд чухал алхамуудыг хийж байна.
- Бичил уурхай эрхлэгчид тухайд тэдний эрхэлж буй үйл ажиллагаа нь албан бус байгаа нь тэдний амьдрал ахуйд хүнд ачаа үүрүүлж байгаа болохоор үйл ажиллагаагаа албан хууль ёсны болгохыг хүсэл эрмэлзэлтэй байна.
- Монгол улсын ард иргэд юуны өмнө ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас нутгийн иргэдэд ашиг тус хүртээх саналыг дэвшүүлдэг болсон.